

ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенц

Удиртгал

- Хүн төрөлхтний сайн сайхан ирээдүй, соёл иргэншлийг хөгжил дэвшлийн төлөө соёлыг түгээх, ард түмэн хоорондын харилцан ойлголцлыг хөхиүлэн дэмжихэд соёлын солилцоо болон соёлын өвийг хамгаалахын ач холбогдлыг ойлгож,
- Соёлын өв /эд зүйл/-ийн хууль бус худалдаа ба ихэнх тохиолдолд түүнээс улбаалан тухайн өв болон үндэстэн, омог, уугуул иргэд, олон нийт, түүнчлэн бүх ард түмний өвийн аль алинд учирч байгаа нөхөж баршгүй хохирол, ялангуяа археологийн талбайд гарсан хулгай дээрмээс болж архелоги, түүх болон шинжлэх ухааны салбарын мэдээлэлд нөхөж баршгүй гарз хохирол бий болж байгаад онцгойлон сэтгэл зовниж,
- Бүх нийтийн ашиг сонирхлын тулд соёлын өвийн хадгалалт ба хамгаалалтыг сайжруулах зорилгоор хэлэлцэгч улс орнуудын хооронд соёлын өвийн эзэмшигчийг тогтоох, буцаан олгох зорилгоор нийтлэг, доод хязгаар бүхий хууль журмыг гаргах замаар соёлын өвийн хууль бус худалдааны эсрэг тэмцэлд үр дүнтэй хувь нэмэр оруулахаар тогтож,
- Энэхүү конвенц нь соёлын өвийн эзэмшигчийг тогтоох, буцаан олгох ажилд дэмжлэг үзүүлэх зорилготой болохыг, мөн зарим улсын соёлын өвийн /эд зүйлийн/ эзэмшигчийг тогтоох, буцаан олгох ажилд нөлөөлөхүйц нөхөн олговор гэх мэт хамгаалалтын аливаа арга хэмжээ авах чухал шаардлагатай байдаг хэдий ч энэ нь бусад улс оронд түүний адил хэрэгжих ёстой гэсэн үг биш болохыг тодотгож,
- Конвенцын заалтуудыг батламжлах нь энэхүү конвенци хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэхээс өмнө тохиолдсон байж болох аливаа төрлийн хууль бус үйл ажиллагааг дэмжих эсвэл хуульчлан хамгаалж байна гэсэн үг биш болохыг бататгаж,
- Энэхүү конвенц нь хууль бус худалдаатай холбоотой асуудлуудад дангаараа шийдэл болохгүй бөгөөд харин олон улсын соёлын хамтын ажиллагааг сайжруулах, соёлын солилцооны асуудлууд болох хууль ёсны худалдаа ба улс хоорондын гэрээ хэлэлцээрт зөв байр суурийг эзлэх үйл явцыг санаачилж байгааг ухамсарлаж,
- Энэхүү конвенцийг хэрэгжүүлэхдээ бүртгэл гаргаж хөтлөх, археологийн олдвор бүхий газар нутгийг хамгаалалтанд авах болон техникийн хамтын ажиллагааг дэмжих зэрэг соёлын өвийг хамгаалах үр дүнтэй бусад арга хэмжээнүүдийг давхар авах шаардлагатай гэдгийг зөвшөөрч,
- Хууль бус худалдаа болон хувийн салбарт код бүртгэлийг хөгжүүлэх тухай 1970 оны ЮНЕСКО-гийн Конвенци зэрэг соёлын өвийг хамгаалах төрөл бүрийн байгууллагуудын үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч конвенцийг батласан.

Тайлбар дүгнэлт: Удиртгалд дурдсан Конвенцын үндсэн зарчим, зорилгыг Монгол улсын соёлын өвийг хамгаалах, соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх бодлого, үйл ажиллагаа /эрх зүйн зохицуулалт/-тай харьцуулбал:

Нээдүгээрт. "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д түүх, соёлын үнэт зүйлс хууль бусаар гадаадад гарахаас сэргийлэх, хууль бусаар гадаадад гаргасан монголын соёлын өвийг эх орондоо эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах, ...гадаад оронтой идэвхтэй хамтран ажиллах эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авна хэмээн заасан нь хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг хэлэлцэн тохирогч улсуудын хооронд эргүүлэн олгох, буцаах конвенцын үндсэн зорилготой шууд нийцнэ.

Хоёрдугаарт. "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хилийн чанад дахь монгол соёлын өвийг сурвалжлан олох, судлах, нэгдсэн каталог хийх, эх орондоо эргүүлэн залах, энэ чиглэлээр бусад улс оронтой идэвхтэй хамтран ажиллана. Үнэ цэн бүхий археологийн дурсгалт газрыг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үнэлгээ

хийж, дурсгалт газруудыг газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгэж, хамгаална. "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" болон "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх зорилгоор хууль, эрх зүйн орчныг сайжруулна, соёлын өвийг хамгаалах тогтвортой механизм бүрдүүлнэ, хилийн чанадад байгаа Монгол Улсын соёлын өвийг бүртгэх ажлыг зохион байгуулна гэсэн нь хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаахаас гадна конвенцын соёлын үнэт зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх, археологийн олдворт газрыг хамгаалах, соёлын өвийн бүртгэл судалгааг хөгжүүлэх агуулгатай тохирно.

Гуравдугаарт. Соёлын өвийг хамгаалах төрөл бүрийн байгууллагуудын хийсэн ажил, тэр дундаа ЮНЕСКО-гийн 1970 оны Конвенц болон Хувийн хэвшлийн ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрч конвенцийг баталсан нь тэдгээрийг дэмжих, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх гол санааг агуулсан гэвэл түүх, соёлын дурсгалт болон үнэт зүйл, байгалийн өвийг хамгаалах, сэргээх талаар гадаад улс, ЮНЕСКО, олон улсын холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллаж, түүхэн шалтгаанаар гадаадад гарсан эд өлгийн зүйлийг сурвалжлан олоход чиглэсэн хамтын ажиллагаа хөгжүүлэх Монгол Улсын соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлоготой нийцэж байна.

I БҮЛЭГ. Хамрах хүрээ ба тодорхойлолт

1 дүгээр зүйл

Энэхүү конвенцыг олон улсын шинжтэй дор дурдсан нэхэмжлэлд хэрэглэнэ. Үүнд:

(а) Хулгайлагдсан соёлын эд зүйлийг эгүүлэн олгох,

(б) Хэлэлцэн тохиролцогч улсын соёлын өвийг хамгаалах зорилгоор соёлын эд зүйлсийн экспортын асуудлыг зохицуулсан хуулийг зөрчиж тухайн улсын нутаг дэвсгэрээс шилжүүлэн гаргасан соёлын эд зүйлсийг (цаашид "хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлс" гэх) буцаах.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл. Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрхтэй.

Иргэний хуулийн 7 дугаар зүйл. /Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч/ 7.1. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна. 7.3. Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.

ИХШХШТХ-ийн 3 дугаар зүйл. /Шүүхэд мэдүүлэх эрх/-ийн 3.1. Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй.

ИХШХШТХ-ийн 189 дүгээр зүйл. /Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харьяалал/ 189.2. Монгол Улсын шүүх дор дурдсан олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэргийг өөрийн харьяалалд хамааруулан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна: 189.2.1. нэхэмжлэлийн хариуцагч нь Монгол Улсад байнга оршин суудаг буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг бол; 189.2.2. нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргасан ба тэдгээрийн аль нэг нь Монгол Улсад байнга оршин суудаг; 189.2.4. бусдад гэм хор учруулсны улмаас Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тухайн этгээдэд хохирол учруулсан;

СӨХТХ-ийн 11 дүгээр зүйл. /Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх/ 11.1. Монгол Улсын Ерөнхийлөгч соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.2. хууль бусаар алдагдсан соёлын өвийг Монгол Улсыг төлөөлөн гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нэхэмжлэх эрхийг итгэмжлэлээр олгох, итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох;

СӨХТХ-ийн 13 дугаар зүйл. /Засгийн газрын бүрэн эрх/ 13.1. Засгийн газар соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 13.1.5. улсын хилээр гарч алдагдсан соёлын биет өвийг эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

СӨХТХ-ийн 52 дугаар зүйл. /Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх/ 52.1.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг, сэргээн засварлах, сурталчлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Засгийн газрын зөвшөөрлөөр нэг жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлнэ. Энэ хэсгийн заалт нь түүний хувилсан эх хуулбарт хамаарахгүй. 52.3.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 52.1-д зааснаас бусад нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг дараах зорилгоор эргүүлэн авчрах нөхцөлтэйгөөр улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

52.3.1.палеонтологи, археологийн олдворыг судалж шинжлүүлэх;

52.3.2.сэргээн засварлах;

52.3.3.гадаад улсад үзэсгэлэнд гаргах;

52.4.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хоёр жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлнэ. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас уг хугацааг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн нэг удаа 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно. 52.7. хууль бусаар гадаадад гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, эсхүл уг хуулийн 52.1, 52.3-т заасны дагуу улсын хилээр гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тэдгээрийг Монгол Улсын өмч болохыг зарлах бөгөөд эргүүлж авчрах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон цагдаагийн байгууллага хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулна.

СӨХТХ-ийн 60 дугаар зүйл. /Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага/ 60.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 60.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Соёлын тухай хуулийн 27 дугаар зүйл. /Олон улсын хамтын ажиллагаа/ 27.1. Олон улсын хамтын ажиллагааг дараах чиглэлээр дэмжиж, хөгжүүлнэ: 27.1.3. хууль бусаар алдагдсан соёлын өвийг эргүүлэн авчрах; 27.2. Төрийн холбогдох байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд энэ хуулийн 27.1-д заасан чиглэлийн дагуу үйл ажиллагаа эрхэлнэ.

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл. /Хулгайлах/ 2.Энэ гэмт хэргийг: 2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж,... үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйл. /Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх/ 3.Энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйл. /Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих/ 1.Хуульд заасны дагуу: 1.4.түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ААҮАТЗТХ-ийн 15 дугаар зүйл. /Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл/ 15.1. Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ. 15.22. Соёлын чиглэлээр: 15.22.1.түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх;

Гаалийн тухай хуулийн 8 дугаар зүйл. /Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглох, хязгаарлах/ 8.4. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалттай барааг хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн хилээр нэвтрүүлнэ.

Монгол Улсын хилээр тарифын бус бусад хязгаарлалттай нэвтрүүлэх бүлэг барааны жагсаалт. Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг сэргээн засварлах, сурталчлах зорилгоор оруулах, гаргах.

Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт. ХХI Хэсэг. Урлагийн бүтээл, цуглуулгын зүйлс ба эртний үнэт, ховор зүйлс /гаргах/ А.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл /Засгийн газрын 1995 оны 241, 1998 оны 126, 1999 оны 110 дугаар тогтоолоор баталсан түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлс хамаарна./ Гагцхүү судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор БСШУЯ-ны тогтоосон хугацаагаар. Б.Түүх, соёлын үнэт болон ердийн дурсгалт зүйл /Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалт, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг БСШУ-ны сайд батална. Энэ бүлэгт БСШУ-ны сайдын тушаалаар батлах түүх, соёлын үнэт дурсгалт зүйлс хамаарна./ Эргүүлж авчрах нөхцөлтэйгээр 2 жилээс дээшгүй хугацаагаар. Амьтан, ургамал эрдэс судлал, анатоми, археологи, палеонтологи, угсаатны зүй болон зоос судлалын чиглэлийн цуглуулга ба цуглуулгын зүйлс. Гаргах горимыг Засгийн газар, БСШУ-ны сайдаас баталсан тухайн зүйлийн зэрэглэлийн дагуу мөрдөнө.

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам. Нэг. Нийтлэг үндэслэл. 1.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хосгүй үнэт дурсгалт зүйлийг сэргээн засварлах, сурталчлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Засгийн газрын зөвшөөрлөөр Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө. Найм. Хариуцлага. 8.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам. Нэг. Нийтлэг үндэслэл. 1.2.Дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх лиценз авахаар хүсэлт гаргах, хүсэлтийг хянан шийдвэрлэх, лиценз олгох, лицензийн хэрэгжилтэд хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө. Ес. Хариуцлага. 9.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.

Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам. Нийтлэг үндэслэл. 1.1. "Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай" Улсын Их хурлын 1998 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Монгол Улсын олон улсын гэрээнд улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэхээр нэр төрлийг нь заасан бараанд экспорт, импортын лиценз /цаашид "лиценз" гэх/ олгоход энэхүү журмыг мөрдөнө.

Тайлбар дүгнэлт: Конвенцид олон улсын шинжтэй нэхэмжлэлийн шаардлагыг нарийн заагаагүй ба хулгайн гэмт хэргийн улмаас алдагдсан соёлын эд зүйл нөгөө хэлэлцэн тохиролцогч улсын нутагт байгаа тохиолдолд гэрээг хэрэглэхээр тусгажээ. Хууль бусаар экспортлосон эд зүйл нь олон улсын шинжтэй нэхэмжлэлд хамрагдах нь ойлгомжтой. Гагцхүү тухайн улсын соёлын эд зүйлсийн экспортын асуудлыг зохицуулсан хуулийг зөрчсөн байхыг шаарддаг. Манай улсын холбогдох хуулиар иргэн, аливаа этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэргийг шийдвэрлэж болохоор байна. Хууль бусаар алдагдсан соёлын өвийг гадаад улсаас нэхэмжлэх, итгэмжлэл олгох бүрэн эрхийг Монгол Улсын өрөнхийлөгч хэрэгжүүлж, Засгийн газар үйл ажиллагааг зохион байгуулахаар хуульчилжээ. Түүнчлэн соёлын эд зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх /оруулах, гаргах/ асуудлыг хууль, жагсаалт, журмаар зохицуулан зөрчсөн тохиолдолд шийтгэл оногдуулж, түүх, соёлын дурсгалт зүйлийг хулгайлах, хууль бусаар хил нэвтрүүлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ. Үүгээр конвенцын 1 дүгээр зүйлд заасан нэхэмжлэлийн шаардлагыг дотоодын хуулийн зохицуулалт хангаж байна.

2 дугаар зүйл

Энэхүү конвенцын хавсралтад дурдсан ангиллын аль нэгд харьяалагдах болон шашны, эсхүл шашны бус шинж чанартай археологи, түүхийн өмнөх үе, түүх, уран зохиол, урлаг, эсхүл шинжлэх ухааны чухал ач холбогдолтой зүйлсийг конвенцын зорилгоор соёлын эд зүйлс гэж ойлгоно.

Соёлын тухай хуулийн 3 дугаар зүйл. /Хуулийн нэр томьёоны тодорхойлолт/ 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1. "соёлын үнэт зүйл" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах, эсхүл хүний оюун санаа, үйлдэхүйн үр дүнд бий болсон соёлын агуулга бүхий биет болон биет бус илэрхийллийг;

СӨХТХ-ийн 3 дугаар зүйл. /Хуулийн нэр томьёоны тодорхойлолт/ 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "соёлын өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг;

3.1.2. "соёлын биет өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг;

3.1.3. "түүх, соёлын үл хөдлөх дурсгал" гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дангаар болон цогцолбор байдлаар орших дурсгалыг;

3.1.4. "түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл" гэж тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг;

СӨХТХ-ийн 4 дүгээр зүйл. /Соёлын өвийн ангилал/ 4.1. Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна. 4.2. Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна.

СӨХТХ-ийн 6 дугаар зүйл. /Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл/ 6.1. Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамааруулна:

Жич: "Хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай 1995 оны юнидруа-гийн конвенцын хавсралт болон Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль, бусад хууль, эрх зүйн актуудад тодорхойлсон соёлын эд зүйл /соёлын биет өв/-ийн ангилалыг заалт тус бүрээр харьцуулж хавсралтаар оруулав. /Хавсралт 4/

Тайлбар дүгнэлт: "Соёлын эд зүйлс" гэж нэрлэсэн боловч ЮНЕСКО-гийн 1970 оны Конвенц -ийн 1 дүгээр зүйлд заасан археологи, түүхийн өмнөх үе, түүх, утга зохиол, урлаг,

шинжлэх ухааны ач холбогдолтой гэж улс бүр үзэж байгаа шашны буюу шашны бус шинж чанартай 11 тодорхойлолтоор ангилсан соёлын үнэт зүйлсийг ЮНИДРУА-гийн Конвенцид тэр хэвээр нь хавсралтаар оруулжээ. Манай улс 1970 оны ЮНЕСКО-гийн конвенцид нэгдэн ороод /дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлээд/ даруй 31 жил өнгөрч буй тул энэ нь бидэнд шинэ зүйл огт биш. Соёлын тухай хуулийн "соёлын үнэт зүйл"-ийн тодорхойлолт дээрх 2 конвенцын ангилалаас илүү өргөн хүрээтэй боловч үүнийг шууд жиших, нэр томъёог хүчээр адилтгахыг оролдох шаардлагагүй юм. Учир нь "конвенцын зорилгоор" гэдгийг анхаарвал зохино. Харин 1995 оны конвенцын хавсралтад дурдсан соёлын эд зүйлийг Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, эрх зүйн актуудад тусгагдсан түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамаарах эд зүйлүүдтэй харьцуулахад: конвенцын хавсралтын (а) ангилал СӨХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.5 заалттай, (в) ангилал мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 52.1, 52.3.1 дэх заалтуудтай, (е) ангилал хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.9 дэх заалтуудтай /мөн энд 6.1.8, 6.1.10, 6.1.11, 6.1.15 дахь заалтуудыг хамааруулав/, (ё) ангилал түүний төрлүүд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалттай, (ж) ангилал хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалттай, (и) ангилал хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.13 дахь заалттай, (и) ангилал хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.16 дахь заалттай тус тус тохирч байна. Харин хавсралтын (б) ангилалд СӨХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.10-т заасан түүхэн үйл явдал болсон дурсгалт газрын холбогдох тодорхой эд зүйлийг хамруулан үзэж болох ба Монгол улсын музейн сан хөмрөгийн дүрэмд заасан тодорхойлтууд таарч байна. Түүнчлэн (г) ангилалд мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.9, 5.1.11-т заасан үл хөдлөх дурсгалуудаас /салгасан/ хэсгийг багтаан үзэж болно. СӨХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.17-д заасан бусад түүх, соёлын дурсгалт зүйлд конвенцын хавсралтын (д), (з) ангилалын эд зүйлийг хамруулж ойлговол манай улсын хууль тогтоомжид тусгагдсан түүх соёлын дурсгалт зүйлс, конвенцын соёлын эд зүйлсийн ангилалтай нийцэж байна. Гэхдээ нэршилийн хувьд үг, үсэггүй яг цав таарсан бус агуулга талаас нь харж дүгнэсэн хэрэг юм. Харин конвенцын хавсралтын (д), (и) ангилалд орсон бичээс, зоос, сийлбэр, тавилга, хуучны хөгжмийн зэмсэгийн зүйлс нь 100-гаас илүү жилийн настай байхыг зааж өгсөн нь онцлог байна.

II БҮЛЭГ. Хулгайлагдсан соёлын эд зүйлийг эргүүлэн олгох

3 дугаар зүйл.

(1) Хулгайлагдсан соёлын эд зүйлийг эзэмшигч тэрхүү зүйлийг буцаана.

Иргэний хуулийн 89 дүгээр зүйл /Эзэмшил үүсэх/-ийн 89.1.Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ.

Иргэний хуулийн 91 дүгээр зүйл. /Эд хөрөнгө эзэмшигчийг өмчлөгч гэж тооцох/ 91.1.Гуравдагч этгээдийн хувьд эд хөрөнгө эзэмшигч нь тухайн эд хөрөнгийн өмчлөгч гэж тооцогдоно.

91.2.Дараахь тохиолдолд энэ хуулийн 91.1 дэх хэсэг хамаарахгүй:

91.2.1.эд хөрөнгийг өмчлөх эрх улсын бүртгэлд үндэслэсэн бол;

91.2.2.мөнгө, мэдүүлгийн үнэт цааснаас бусад эд хөрөнгө нь өмнөх өмчлөгчийн хүсэл зоригоос үл хамаарах /гээгдүүлэх, хулгайд алдах гэх мэт/ үндэслэлээр эзэмшлээс нь гарсан бол өмнөх өмчлөгчийн хувьд.

Иргэний хуулийн 94 дүгээр зүйл. /Шударга эзэмшигчийн эрх, үүрэг/ 94.1.Эд хөрөнгийг эзэмших эрхгүй буюу энэ эрхээ алдсан шударга эзэмшигч нь уг эд хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцаан өгөх үүрэгтэй.

Иргэний хуулийн 106 дугаар зүйл. /Өмчлөгчийн шаардах эрх/ 106.1. Өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй.

(2) Хууль бус малтлагын үр дүнд олдсон, эсхүл хууль ёсны малтлагын үр дүнд олдсон боловч хууль бусаар авч үлдсэн соёлын эд зүйлийг тухайн малтлага хийгдсэн улсын хуульд нийцэж буй бол энэхүү конвенцын зорилгоор хулгайлагдсан гэж үзнэ.

Эрүүгийн хуулийн 25.4 дүгээр зүйл. /Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх/ 1.Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага, судалгаа хийсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 25.3 дугаар зүйл. /Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх/ 1.Соёлын биет өвийг завшсан, үрэгдүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйл. /Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих/ 8. Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад илэрсэн соёлын биет өвийг хамгаалах, мэдээлэх арга хэмжээ аваагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйл. /Гэрээлэгчийн эрх, үүрэг/ 11.1.Гэрээлэгч дараах эрх эдэлнэ: 11.2.15.үйл ажиллагааных нь явцад түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд тухайн газарт явуулж байгаа үйл ажиллагаагаа зогсоон, нэн даруй холбогдох байгууллагад мэдэгдэх;

Газрын хэвлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. /Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг/ 2.Газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан шаардлагыг хангах үүрэгтэй: 5/газрын хэвлийг ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу болон шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах.

Ашигт малтмалын тухай хуулийн 40¹ дүгээр зүйл. /Соёлын өвийг хамгаалах/ 40¹.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 40², 46 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.

40¹.2.Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.

Ашигт малтмалын тухай хуулийн 40² дугаар зүйл. /Соёлын өвийг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг/ 40².1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь соёлын өвийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

40².1.2.ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйл. /Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг/ 25.4.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах явцад өөр төрлийн ашигт малтмал, түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд үйл ажиллагаагаа зогсоож аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ.

Иргэний хуулийн 118 дугаар зүйл. /Дарагдмал үнэт зүйл/

118.3. Дарагдмал үнэт зүйлс дотор түүх, соёлын дурсгалт зүйл байвал тэдгээрийг төрийн өмчлөлд шилжүүлнэ. Энэ тохиолдолд дарагдмал үнэт зүйл олдсон газрын буюу эд хөрөнгийн өмчлөгч болон эд юмсыг олсон этгээдэд түүний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх мөнгөн шагналыг тэнцүү хувааж олгоно.

118.4. Хайгуул, малталт хийх албан үүрэг бүхий этгээд уг үүргээ гүйцэтгэх явцдаа илрүүлсэн дарагдмал үнэт зүйлс, археологийн болон палентологийн олдворт энэ зүйлд заасан журам хамаарахгүй.

СӨХТХ-ийн 27 дугаар зүйл. /Соёлын өвийн судалгаа/ 27.1.Соёлын биет өвийн судалгаа, шинжилгээг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ.

27.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх болон соёлын биет бус өвийн судалгаа хийх зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх харьяалах Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

27.4.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журмыг соёлын болон шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

27.5.Эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад олгоно.

СӨХТХ-ийн 30 дугаар зүйл. /Олдвор/ 30.4.Олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Соёлын өвийн судалгаа хийх журам. Нэг. Нийтлэг үндэслэл. Монгол Улсын нутаг дэвсгэрт палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага, судалгааны ажил хийхэд энэ журмыг мөрдөнө.

(3) Аливаа эгүүлэн олгох нэхэмжлэлийг, тухайн хулгайлагдсан эд зүйлийн байршил, түүнийг эзэмшигч этгээдийг нэхэмжлэгч нь тогтоосон цагаас хойш 3 жилийн дотор, аль ч тохиолдолд тухайн эд зүйл хулгайлагдсан цагаас хойш 50 жилийн дотор мэдүүлнэ.

(4) Харин тодорхой хөшөө дурсгал, археологийн дурсгалт газар, эсхүл нийтийн цуглуулгын салшгүй хэсэг болох соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэл нь цаг хугацаагаар хязгаарлагдахгүй бөгөөд гагцхүү соёлын эд зүйлийн байршил болон эзэмшигчийг нэхэмжлэгч нь тогтоосон цагаас хойш гурван жилийн хугацаанд мэдүүлнэ.

Иргэний хуулийн 74 дүгээр зүйл. /Хөөн хэлэлцэх хугацаа хамаарах шаардах эрх/ 74.1.Хуульд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүйгээр зааснаас бусад тохиолдолд өөр этгээдээс ямар нэг үйлдэл хийх буюу хийхгүй байхыг шаардах эрх хөөн хэлэлцэх хугацаатай байна.

Иргэний хуулийн 75 дугаар зүйл. /Хөөн хэлэлцэх ерөнхий болон тусгай хугацаа/ 75.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа арван жил байна.

Иргэний хуулийн 90 дүгээр зүйл. /Шударга эзэмшигч/ 90.2.Шударга эзэмшигч өөрийн эзэмшлээс алдсан эд хөрөнгөө гурван жилийн дотор шинэ эзэмшигчээс буцаан шаардах эрхтэй. **90.3.**Хууран мэхлэх, хүч хэрэглэх замаар эд хөрөнгийг олж авснаас бусад тохиолдолд шинэ эзэмшигч тухайн эд хөрөнгийн хувьд өмнөх эзэмшигчээс илүү эрхтэй бол энэ хуулийн 90.2-т заасан журам үйлчлэхгүй.

СӨХТХ-ийн 8 дугаар зүйл. /Соёлын өвийн зэрэглэл/ 8.1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтын зэрэглэл тогтооно. **8.2.**Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан үнэт, хосгүй үнэт зэрэглэл тогтооно.

(5) Хэлэлцэн тохиролцогч аливаа улс өмнөх хэсгийн заалтыг үл харгалзан нэхэмжлэл гаргах хугацааг 75 жил, эсхүл өөрийн хуульд зааснаар илүү урт хугацаагаар тогтоосноо мэдэгдэж болно. Ийм мэдэгдэл хийсэн Хэлэлцэн тохиролцогч улсад байгаа хөшөө дурсгал,

археологийн дурсгалт газар, эсхүл нийтийн цуглуулгаас салган авсан соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэлийг өөр Хэлэлцэн тохиролцогч улсад гаргахдаа заасан хязгаарлах хугацаанд захирагдана.

(6) Өмнөх хэсэгт дурдсан мэдэгдлийг гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох үед хийнэ.

Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйл. /Хуулийн нэр томъёоны тодорхойлолт/ 3.1.7."тайлбар" гэж олон улсын гэрээ байгуулахдаа тухайн гэрээний тодорхой заалтыг Монгол Улсын хувьд хэрэгжүүлэхэд хуулийн үйлчлэлийг нь хасах, эсхүл өөрчлөх зорилгоор энэ хуульд заасны дагуу гаргасан мэдэгдлийг;

Олон улсын гэрээний тухай хуулийн 16 дугаар зүйл. /Олон улсын гэрээг соёрхон батлах/ 16.4.Улсын Их Хурал олон талт олон улсын гэрээг соёрхон батлахдаа тайлбар хийхээр шийдвэрлэсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуульд энэ тухай тусгай заалт оруулна.

Олон улсын гэрээний тухай хуулийн 21 дүгээр зүйл. /Тайлбар хийх, эсэргүүцэх, эгүүлэн авах/ 21.1.Улсын Их Хурал, Засгийн газар олон талт олон улсын гэрээг соёрхон батлах, батлахдаа тайлбар хийсэн бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан Монгол Улсын хууль, баталсан Засгийн газрын тогтоолыг орчуулж тухайн олон улсын гэрээний зохицуулалтын дагуу холбогдох улс, эсхүл олон улсын байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авна.

21.2.Энэ зүйлийн 21.1-д заасны дагуу үйлдсэн тайлбарыг тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан тухай Батламж жуух бичиг, эсхүл баталсан тухай баримт бичигтэй хамт хүргүүлнэ.

21.3.Олон талт олон улсын гэрээнд тайлбар хийх саналыг боловсруулахдаа тухайн олон улсын гэрээгээр тайлбар хийх боломжтой эсэх, тайлбар хийх боломжит хүрээ, тухайн олон улсын гэрээний бусад талын, эсхүл олон улсын байгууллагын зөвшөөрөл шаардлагатай эсэх зэрэг зохицуулалтыг харгалзана.

(7) Энэхүү конвенцын зорилгоор бүртгэгдсэн, эсхүл өөр байдлаар тодорхойлогдсон соёлын бүлэг эд зүйлсээс бүрдэх "нийтийн цуглуулга" нь дор дурдсан өмчлөлд байна.

(a) Хэлэлцэн тохиролцогч улсын,

(b) Хэлэлцэн тохиролцогч улсын бүс нутгийн, эсхүл орон нутгийн эрх бүхий байгууллагын,

(c) Хэлэлцэн тохиролцогч улсын шашны байгууллагын, эсхүл

(d) соёл, боловсрол болон шинжлэх ухааны зорилгоор Хэлэлцэн тохиролцогч улсад байгуулагдан нийтийн ашиг сонирхлын төлөө үйлчлэхээр хүлээн зөвшөөрөгдсөн аливаа нэгэн байгууллагын

(8) Үүнээс гадна Хэлэлцэн тохиролцогч улсын уугуул иргэд, овог аймагт хамааралтай бөгөөд тэдний уламжлал, эсхүл зан үйлд хэрэглэдэг тухайн нийгмийн бүлэгт ач холбогдолтой, ариун нандин соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэл нь нийтийн цуглуулгын хувьд мөрдөж буй хугацааны хязгаарт хамрагдана.

Иргэний хуулийн 99 дүгээр зүйл. /Өмчийн төрөл, хэлбэр/ 99.1.Монгол Улсад нийтийн болон хувийн өмч байна. 99.2.Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна. 99.4.Нийтийн болон хувийн өмч нь холимог хэлбэрээр байж болно.

Иргэний хуулийн 100 дугаар зүйл. /Өмчлөгч/ 100.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төр, аймаг, нийслэл, сум, дүүрэг, иргэн болон хуулийн этгээд өмчлөгч байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. /Төрийн нийтийн зориулалттай өмч/ 1.Үндсэн хууль, бусад хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан зүйлсийг төрийн нийтийн зориулалттай өмч гэнэ.

2.Төрийн нийтийн зориулалттай өмчид дараахь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө хамаарна:

6/ түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал; 7/ археологийн болон палентологийн олдвор;

СӨХТХ-ийн 31 дүгээр зүйл. /Соёлын биет өвийг эзэмших/ 31.1.Нийтийн өмчийн соёлын биет өвийг төрийн болон орон нутгийн, шашны, олон нийтийн байгууллага өмчлөгчийн тогтоосон нөхцөлөөр тус тус эзэмшинэ. 31.2.Доор дурдсан байгууллага, хуулийн этгээд нийтийн өмчийн соёлын биет өвийг эзэмшинэ:

31.2.1.төрийн болон орон нутгийн музей;

31.2.2.галерей;

31.2.3.эрдэм шинжилгээний байгууллага;

31.2.4.үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн номын сан;

31.2.5.үндэсний төв архив, аймаг, нийслэлийн архив;

31.2.6.шашны байгууллага;

31.2.7.хууль тогтоомжоор соёлын өвийг хадгалж, хамгаалах үүрэг хүлээлгэсэн бусад байгууллага.

СӨХТХ-ийн 20 дугаар зүйл. /Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо/ 20.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь дараах тогтолцоотой байна:

20.1.1.байгууллагын бүртгэл, мэдээллийн сан;

20.1.2.сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан;

20.1.3.аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан;

20.1.4.улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан.

20.2.Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санг соёлын төвд; аймгийн бүртгэл, мэдээллийн санг орон нутгийн музейд; нийслэлийн бүртгэл, мэдээллийн санг нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжид; улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг Соёлын өвийн үндэсний төвд тус тус бүрдүүлж, хадгална. 20.3.Соёлын өвийн үндэсний төв нь соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна. 20.4.Төрийн болон орон нутгийн музей нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна. 20.5.Сум, дүүргийн соёлын төв нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэн баримтжуулах, хамгаалах үүргийг гүйцэтгэнэ.

20.6.Дараах аж ахуйн нэгж, байгууллага бүртгэл, мэдээллийн санг заавал бүрдүүлнэ:

20.6.1.Монголбанк;

20.6.2.дурсгалт газрын хамгаалалтын захиргаа;

20.6.3.музей, галерей, номын сан, сүм хийд;

20.6.4.эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны лаборатори;

20.6.5.үндэсний төв архив.

20.7.Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд иргэн, хуулийн этгээд өөрийн өмчилж, эзэмшиж байгаа соёлын өвийг бүртгүүлж болно.

20.9.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь төрийн өмчид байна.

СӨХТХ-ийн 22 дугаар зүйл. /Соёлын өвийг бүртгэх/ 22.2.Нийтийн өмчийн соёлын биет өвийн талаарх мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгэнэ.

Соёлын тухай хуулийн 12 дугаар зүйл. /Соёлын үнэт зүйлийн бүртгэл/

12.1.Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах чиг үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

12.2.Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.3.Соёлын үнэт зүйлийн үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан соёлын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр төрөлжсөн мэдээллийн сангаас бүрдэх бөгөөд төрөлжсөн мэдээллийн сангийн үйл ажиллагааг холбогдох хууль болон энэ хуулийн 12.2-т заасан журмаар зохицуулна.

12.4.Гадаад улсад байгаа монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийг үндэсний бүртгэл, мэдээллийн санд бүртгэж болно.

Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам. Нэг. Нийтлэг үндэслэл 1.1. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх, соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоог бий болгох, улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлж, соёлын өвийг уг санд бүртгэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө. 1.2. Журмын зорилго нь Монгол Улсын хэмжээнд түүх, соёлын хөдлөх болон үл хөдлөх дурсгал, утга соёлын өв (биет бус)-ийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлж, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр соёлын өвийг уг санд бүртгэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Музейн тухай хуулийн 4 дүгээр зүйл. /Хуулийн нэр томъёоны тодорхойлолт/ 4.1.1."музей" гэж соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус соёл, эрдэм шинжилгээний байгууллагыг; 4.1.3."өрөнхий бүртгэл" гэж үзмэрийн хувийн дугаар, нэр, тоо, хэмжээ, тодорхойлолт бүхий бүртгэл, мэдээллийн баримт бичгийг; 4.1.4."үзмэр" гэж өрөнхий бүртгэлд бүртгэгдсэн музейн өмчийн соёлын үнэт зүйлийг; 4.1.5."цуглуулга" гэж нэг болон хэд хэдэн шинжээрээ харилцан холбоотой, тодорхой цаг үеийг төлөөлөх шинжлэх ухаан, урлаг, танин мэдэхүйн ач холбогдолтой үзмэрийн бүрдэл хэсгийг;

Музейн тухай хуулийн 5 дугаар зүйл. /Музей байгуулах/ 5.1.Музейг төрийн болон орон нутгийн, хувийн өмчийн хэлбэрээр Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байгуулна.

Номын сангийн тухай хуулийн 5 дугаар зүйл. /Номын сангийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг үүсгэн байгуулах, татан буулгах/ 5.1.Номын сангийн үйл ажиллагааг номын сангийн орчны стандартыг хангасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллага, иргэн эрхэлж болно.

Номын сангийн тухай хуулийн 7 дугаар зүйл.Үндэсний номын сангийн эрх зүйн байдал

7.1.Монгол Улсын Үндэсний номын сан /цаашид "Үндэсний номын сан" гэх/ нь монголын ард түмний бичиг үсгийн дурсгалыг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үүрэг бүхий байгууллага байна. 7.5.Үндэсний номын сангийн сан хөмрөг төрийн хамгаалалтад байна.

Номын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. /Үндэсний номын сангийн үүрэг/ 9.4.1.түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах ном, судрыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу бүртгүүлж, хамгаалах;

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйл. /Хуулийн нэр томъёоны тодорхойлолт/ 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."эрдэнэс" гэж түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, байгалийн төрцийг;

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. /Эрдэнэсийн сан, түүний ангилал/ 4.3.Үндсэн сан байнгын болон байнгын бус хэсгээс бүрдэнэ.

4.4.Үндсэн сангийн байнгын хэсэгт Монгол Улсын хуваагдашгүй өмч болох эрдэнэс байх бөгөөд тэдгээрийг худалдах, шилжүүлэх, захиран зарцуулахыг хориглоно.

4.5.Үндсэн сангийн байнгын бус хэсэгт олон улсын жишгээр цэвэршүүлсэн үнэт металл, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын үнэт дурсгалт зүйл, үнэт болон бусад металаар хийж нөөцөд авсан зоос байна.

4.6.Үндсэн сангийн байнгын хэсэгт байх түүх, соёлын дурсгалт зүйл нь хосгүй үнэт зэрэглэлтэй байна.

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйл. /Эрдэнэсийн сангийн бүртгэл/

12.1.Монголбанк Эрдэнэсийн сангийн эрдэнэс, бусад хөрөнгийн хувийн хэргийг хөтөлж, Эрдэнэсийн сангийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэнэ.

12.2.Монголбанк Эрдэнэсийн сангийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, өөрийн санхүүгийн тайланд тусгана.

12.3.Энэ хуулийн 12.1-д заасан бүртгэл, мэдээллийн сангийн журмыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 6 дугаар зүйл. /Шашны байгууллага/ 1.

Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг /цаашид энэ хуульд "сүм хийд гэх / шашны байгууллага гэнэ.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11 дүгээр зүйл. /Сүм хийдийн өмч, аж ахуйн харилцааг зохицуулах/ 1.Сүм хийдийн өмч, аж ахуйн харилцааг Монгол Улсын

холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна. 2.Сүм хийд өөрийн эзэмшилд болон өмчлөлд байгаа газраас үл салах түүх, соёлын үл хөдлөх дурсгал, бусад үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд, дурсгалын талаарх мэдээллийг соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлнэ.

Архив, албан хэрэг хөтлөлттийн тухай хуулийн 10 дугаар зүйл. /Үндэсний архивын

сан хөмрөгийн бүрэлдэхүүн/ 10.1.Үндэсний архивын сан хөмрөг нь төрийн ой санамж, Монгол Улсын түүх, соёлын өв болохын хувьд өмчийн хэлбэрээс үл хамааран төрийн хамгаалалтад байна.

Шинжлэх ухаан, технологийн тухай 11 дүгээр зүйл. /Эрдэм шинжилгээний

байгууллага/ 11.1.Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг хуулийн этгээдийг эрдэм шинжилгээний байгууллага гэнэ. 11.2.Эрдэм шинжилгээний байгууллагыг дор дурдсан хэлбэрээр байгуулж болно: 11.2.4.төрийн болон орон нутгийн музей, үндэсний соёлын байгууллага.

СӨХТХ-ийн 6 дугаар зүйл. /Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл/ 6.1.Дараах соёлын

биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамааруулна: 6.1.7.угсаатны хувцас, чимэглэл; 6.1.8.уламжлалт аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг; 6.1.9.угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл; 6.1.10.уламжлалт тоглоом, наадгай; 6.1.11.уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл; 6.1.15. уламжлалт монгол эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэрэглэгдэхүүн, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;

Тайлбар дүгнэлт: Иргэний хуульд эд хөрөнгийг өмчлөгч бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй бөгөөд эзэмших эрхгүй этгээд буцаах үүрэгтэй гэсэн нь конвенцын 3 дугаар зүйлийн (1) заалттай нийлнэ. Монгол Улсын хууль тогтоомжоор газрын хэвлийг ашиглагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч нь газрын хэвлийг ашиглах, ашигт малтмал хайх, олборлох явцад илэрсэн түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалалтанд авч, холбогдох байгууллагад мэдэгдэх бөгөөд олдвор, эд өлгийн зүйлийг улсад өгөх үүрэгтэй. Харин дарагдмал үнэт зүйлс олсон этгээд түүний дотор түүх, соёлын дурсгалт зүйл байвал тэдгээрийг төрийн өмчлөлд шилжүүлж, үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх мөнгөн шагнал авна. Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааг зохих зөвшөөрөлтэйгөөр,

тогтоосон журмын дагуу зөвхөн мэргэжлийн байгууллага хийх бөгөөд хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийсэн, эсхүл соёлын биет өв /олдвор/-ийг завшсан /хууль бусаар авч үлдсэн/ үйлдлийг гэмт хэрэгт тооцох тул (2) конвенцын зорилгын дагуу "хулгайлагдсан" гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Уг зүйлийн (3) дэх хэсэгт нэхэмжлэлийн хязгаарлах /харьцангуй болон үнэмлэхүй/ хугацааг 3 ба 50 жил гэж гэж тогтоосон нь Иргэний хуулийн шударга эзэмшигчийн шаардах эрхийн хугацаа /3 жил/-тай адил, хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа /10 жил/-наас урт байна. Хулгайлагдснаас хойш 50 жилийн дотор гэдэг нь боломжийн урт хугацаа юм. Мөн (4) хэсэгт тодорхой хөшөө дурсгал, археологийн дурсгалт газар, эсхүл нийтийн цуглуулгын салшгүй хэсэг болох соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэлд үнэмлэхүй хязгаарлах /хөөн хэлэлцэх/ хугацааг хэрэглэхгүй байхаар заажээ. Энэ нь СӨХТХ-ийн дагуу зэрэглэл тогтоож хамгаалсан түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хосгүй үнэт, үнэт зүйл, соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн тухайд чухал ач холбогдолтой. (5) Нэхэмжлэл гаргах үнэмлэхүй хугацаа /хөөн хэлэлцэх/-г 75 жил, дотоодын хууль тогтоомжид заасны дагуу илүү урт хугацаагаар тогтоосноо (6) конвенцыг соёрхон батлах /нэгдэн орох/ үедээ мэдэгдэхээр тусгасан нь хэлэлцэн тохиролцогч улсын холбогдох хуулийн заалтыг харгалзан үзсэн зохицуулалт байна. Ийм мэдэгдэл хийсэн улсад нэхэмжлэл гаргасан, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авсан улс хязгаарлах хугацаа тогтоогоогүй, эсхүл илүү урт хугацаагаар тогтоосон байсан ч тус хугацааг дагаж мөрдөнө. Одоогоор Хятад, Гватемал, Мьянмар, Эквадор улсууд конвенцид нэгдэн орохдоо, Голланд улс гарын үсэг зурахдаа мэдэгдэл хийжээ. /Хавсралт 5/ Манай улсын хууль тогтоомжоор нэхэмжлэлийн хугацааг 75, түүнээс илүү урт хугацаагаар тогтоогоогүй тул ийм мэдэгдэл хийх шаардлагагүй. Өөрөөр хэлбэл тодорхой хөшөө дурсгал, археологийн дурсгалт газар, эсхүл нийтийн цуглуулгын салшгүй хэсэг болох соёлын эд зүйлийг эгүүлэн авахад хугацаанд хязгаарлагдахгүй байх нь ашигтай. Конвенцид заасан (7) нийтийн цуглуулгад хамаарах бүртгэгдсэн, тодорхойлогдсон соёлын эд зүйлийн өмчлөгчийн ангилалд Монгол Улсын хуулиар тогтоосон нийтийн өмчийн соёлын биет өвийг эзэмших, өмчлөх, хамгаалах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгүүлэх эрх, үүрэг бүхий субъектүүд бүгд багтаж байна. Түүнчлэн соёл, боловсрол болон шинжлэх ухааны зорилгоор нийтэд үйлчилж буй ашгийн төлөө бус соёл, эрдэм шинжилгээний байгууллага болохын хувьд хувийн өмчийн музейн үзмэр, цуглуулга ч хамрагдах боломжтой ажээ. (8) Хулгайлагдсан соёлын эд зүйл нь уугуул иргэд, овог аймагт хамааралтай, тэдний уламжлалт зан үйлд хэрэглэдэг зүйл бол "нийтийн цуглуулга"-ын адил үнэмлэхүй хязгаарлах хугацаа байхгүй. СӨХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт овог, уугуул иргэд, овог аймаг гэж нэрлээгүй ч угсаатан, ястаны болон уламжлалт шашин, зан үйлтэй холбоотой эд өлгийн зүйлийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамруулжээ.

4 дүгээр зүйл

(1) Буцаах шаардлагатай хулгайлагдсан соёлын эд зүйлийг эзэмшигч нь тухайн эд зүйлийг хулгайлагдсан гэдгийг мэдээгүй, мэдэх боломжгүй байсан бөгөөд тухайн эд зүйлийг худалдан авах үедээ нарийвчилсан хяналт, шалгалт хийснээ нотолж чадсан тохиолдолд шударга бөгөөд зохих нөхөн олговрыг авах эрхтэй.

(2) Нэхэмжлэлийг хүлээн авсан улсын хуульд нийцсэн тохиолдолд өмнөх хэсэгт дурдсан эзэмшигчийн нөхөн олговор авах эрхийг хөндөхгүйгээр эзэмшигчид тухайн соёлын эд зүйлсийг шилжүүлсэн, эсхүл түүнийг урьд нь шилжүүлж байсан этгээдээр нөхөн олговор төлүүлэхэд тодорхой хүчин чармайлтыг гаргана.

(3) Нэхэмжлэгч нь эзэмшигчид нөхөн олговор олгох шаардлагатай тохиолдолд аливаа бусад этгээдээр төлүүлэх эрхтэй байна.

Иргэний хуулийн 114 дүгээр зүйл. /Өмчлөх эрхийг шударгаар олж авах/ 114.1.Эд хөрөнгө шилжүүлж байгаа этгээд нь өмчлөгч биш болохыг өмчлөх эрх олж авч байгаа этгээд мэдээгүй бөгөөд мэдэх боломжгүй байсан бол түүнийг өмчлөх эрхийг шударгаар олж авсан гэж тооцно. Харин эрхээ шилжүүлж байгаа этгээд өмчлөгч биш болохыг тухайн үед мэдэж байсан буюу мэдэх ёстой буюу мэдэх боломжтой байсан бол өмчлөх эрхийг шударгаар олж авсан гэж үзэхгүй.

Иргэний хуулийн 94 дүгээр зүйл. /Шударга эзэмшигчийн эрх, үүрэг/ 94.3. Шударга эзэмшигч нь эд хөрөнгийг шударгаар эзэмшиж байхдаа түүнийг хадгалах, арчлах, засан сайжруулах зэрэгт зарцуулсан зардлыг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй. 94.6. Шударга эзэмшигч, өөрийн шаардлага хангагдах хүртэл эд хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцааж өгөхөөс татгалзах эрхтэй.

Иргэний хуулийн 493 дугаар зүйл. /Буцаан шаардах шаардлагад хамаарах зүйлс/ 493.5.Эд хөрөнгө олж авсан этгээд тухайн хөрөнгийг бүрмөсөн өөрийн болгосон гэж бодсоны улмаас түүнтэй холбоотой зардал гаргасан бол зардал, хохирлоо нөхөн төлүүлж уг зүйлийг буцааж өгөх үүрэгтэй. Харин хөрөнгийн шинж байдлаас түүнийг бүрмөсөн өөрийн болгож авсан гэж бодох үндэслэлгүй нь илтэд байвал энэ журам үл хамаарна. 493.6. Бусдын эд хөрөнгийг үндэслэлгүйгээр, шударга бусаар олж авсан этгээд ийнхүү эд хөрөнгийг олж авсан үеэс, шударгаар олж авсан этгээд нь үндэслэлгүйгээр олж авсан гэдгээ мэдсэн буюу мэдэх ёстой байсан үеэс эхлэн уг хөрөнгөөс олсон буюу өөрийн буруугаас олж чадаагүй зайлшгүй олох ёстой байсан орлого үр шимийг хууль ёсны өмчлөгч буюу эзэмшигчид буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэг хүлээнэ.

ЭХХШТХ-ийн 8.5 дугаар зүйл. /Иргэний нэхэмжлэгч/ 1. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ. 2. Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ. 6. Гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно.

ЭХХШТХ-ийн 8.6 дугаар зүйл. /Иргэний хариуцагч/ 1. ...түүнчлэн гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хууль ёсоор хариуцвал зохих хүн, хуулийн этгээдийг иргэний хариуцагчаар татан оролцуулж болно.

(4) Эзэмшигч нь зохих идэвх зүтгэл гаргасан эсэхийг тогтооход худалдан авалтын үеийн бүхий л нөхцөл байдал, тухайлбал талуудын тухай мэдээлэл, төлсөн үнэ, эзэмшигч нь хулгайлагдсан соёлын эд зүйлсийн талаарх хялбар олох боломжтой бүртгэл, аливаа бусад холбогдох баримт, мэдээлэлтэй танилцсан эсэх, хандаж болох эрх бүхий байгууллагаас зөвлөгөө авсан эсэх болон эзэмшигч нь тухайн нөхцөл байдалд эрх зүйн чадамжтай этгээд авч чадах бүхий л арга хэмжээг авсан эсэхийг харгалзаж үзнэ.

(5) Эзэмшигч нь түүнд тэрхүү соёлын эд зүйлийг өвлүүлсэн, эсхүл бэлгийн журмаар өгсөн этгээдээс илүү эрх эдлэхгүй.

Иргэний хуулийн 243 дугаар зүйл. /Худалдах-худалдан авах гэрээ/ 243.1.Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ. 243.2.Худалдагч нь худалдаж байгаа эд хөрөнгийн зориулалт, хэрэглээний шинж чанар, хадгалах, хэрэглэх,

тээвэрлэх нөхцөл, журам, баталгаат болон эдэлгээний хугацаа, үйлдвэрлэгчтэй холбогдсон үнэн зөв, бүрэн мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.

Иргэний хуулийн 197 дугаар зүйл. /Үнэ хаялцуулах ажиллагаа/ 197.1.Үнэ хаялцуулах замаар гэрээ байгуулж болно.**197.2.**Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээг үнэ хаялцаж ялсан этгээдтэй байгуулна.**197.3.**Үнэ хаялцуулах ажиллагааг зохион байгуулагч нь өмчлөгч буюу эрх эзэмшигч, эсхүл эрх олгогдсон этгээд байж болно.**197.4.**Эрх олгогдсон байгууллага өмчлөгч буюу эрх эзэмшигчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр тэдгээрийн нэрийн өмнөөс, эсхүл өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

Иргэний хуулийн 549 дүгээр зүйл. /Гэрээний талууд хуулийг сонгох/ 549.1.Гэрээний дагуу эдлэх эрх, үүрэг, гэрээний агуулга, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, гэрээ дуусгавар болох буюу хүчин төгөлдөр бус болох, гэрээний үүргээ гүйцэтгэхгүй буюу зохих ёсоор гүйцэтгэхгүй байх зэрэг асуудлаас үүсэх үр дагаврыг гэрээ байгуулагч талууд харилцан тохиролцож тодорхойлсон улсын хуулиар зохицуулна. **549.7.**Биржийн хэлцэл, үнэ хаялцуулах ажиллагааны үр дүнд байгуулагдсан гэрээнд тухайн биржийн хэлцэл хийсэн буюу үнэ хаялцуулах ажиллагаа явуулсан улсын хуулийг хэрэглэнэ.

Иргэний хуулийн 494 дүгээр зүйл. /Хөрөнгийг буцаан шилжүүлэх гуравдагч этгээдийн үүрэг/ 494.1.Үндэслэлгүйгээр хөрөнгө олж авсан этгээд тухайн хөрөнгийг гуравдагч этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлсэн тохиолдолд гуравдагч этгээд уг хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцаан шилжүүлэх үүрэгтэй.

СӨХТХ-ийн 24 дүгээр зүйл. /Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах/ 24.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр иргэн, хуулийн этгээдэд ашиглуулж болно. Мэдээллийг ашиглуулахдаа өмчлөгч, эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хөндөж үл болно. **24.2.**Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн мэдээллээр нийтэд зориулан сурталчилгааны хялбаршуулсан бүтээл гаргаж болно. **24.3.**Соёлын биет өв алдагдсан тохиолдолд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хариуцсан байгууллага холбогдох мэдээллийг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагад нэн даруй хүргүүлэх арга хэмжээ авна.

СӨХТХ-ийн 35 дугаар зүйл. /Соёлын биет өвийг худалдах, худалдан авах/ 35.1.Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **35.2.**Соёлын биет өвийг худалдан авах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, улс, орон нутгийн музей, номын сан олон нийтэд нээлттэй, ил тод хэлбэрээр зохион байгуулна. **35.4.**Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд худалдахыг хориглоно.**35.5.**Палеонтологи, археологийн олдворыг худалдахыг хориглоно.

Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйл. /Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих/ 3.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавихгүйгээр худалдсан, эсхүл гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлсэн, эсхүл зуучилсан бол уг дурсгалт зүйлийг хураан авч улсын орлого болгон хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эрүүгийн хуулийн 25.5 дугаар зүйл. /Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах/ 1.Соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. **2.**Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар дүгнэлт: (1) Конвенцын энэ зүйлд эзэмшигч нь соёлын эд зүйлийг худалдан авахдаа тухайн эд зүйл хулгайлагдсан гэдгийг мэдээгүй, мэдэх боломжгүй байсныг тодотгосон бол Иргэний хуулийн 114 дүгээр зүйлд эзэмшигч нь эд хөрөнгийг шилжүүлэн авахдаа шилжүүлж байгаа этгээд өмчлөгч биш болохыг мэдээгүй, мэдэх боломжгүй байсныг онцолсон байна. Конвенцид эд хөрөнгийн шинж байдлыг, Иргэний хуульд өмчлөгчийн эрх зүйн байдлыг тусгасан хэдий ч агуулга нь адил юм. Конвенцын ёсоор худалдан авах үедээ тухайн соёлын эд зүйл хууль ёсны эсэхийг мэдэх гэсэн оролдлого, хяналт, шалгалт хийснээ нотлох ёстой. Дотоодын хуулиар соёлын эд зүйлийн худалдаанд хянамгай хандах болон нөхөн олговор авах талаар шууд зохицуулалт байхгүй ба Иргэний хуулийн дагуу шударга эзэмшигч тухайн эд хөрөнгийг хадгалах, арчлах, засан сайжруулах зэрэгт зарцуулсан зардалаа шаардах эрхтэй бол шударга бусаар, үндэслэлгүйгээр эд хөрөнгө олж авсан этгээд уг хөрөнгөнөөс олсон, олох ёстой байсан орлого, үр шимийг хууль ёсны өмчлөгч, эзэмшигчид төлөх үүрэгтэй байна. Гэхдээ конвенцид дээрх зардал, орлого, үр шимийг нөхөн олговорт багтаах талаар нарийвчлан заагаагүй тул шүүх нөхөн олговорын хэмжээг тогтоохдоо харгалзаж болох юм. (2) Шударга эзэмшигчид соёлын эд зүйлийг шилжүүлсэн этгээд тухайн эд зүйлийг хулгайлж аваад шилжүүлсэн /худалдсан/, эсхүл дамжуулан шилжүүлсэн /худалдсан/ ч байсан ч хамаагүй түүгээр нөхөн олговорыг төлүүлэх бүх боломжийг ашиглахыг энэ заалтаар дэмжжээ. Соёлын эд зүйл нь хэд хэдэн этгээдийг дамжин худалдагдсан /шилжигдсэн/ байвал нэхэмжлэлийн асуудалд нэлээд ээдрээ үүсэх ба сунжирч болзошгүй. Гол нь нэхэмжлэл хүлээн авагч улсын хуульд нийцсэн байх шаардлагатай. ЭХХШТХ-д гэмт хэргийн улмаас хохирсон хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээд /иргэний хариуцагч/-д холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргаж, шүүх хэргийн хамт хянан шийдвэрлэхээр заасан байна. Товчхондоо соёлын эд зүйлийг хулгайлж шилжүүлсэн этгээдээс хохиролоо гаргуулж, шударга эзэмшигчид олгох нөхөн олговорыг төлж болно. (3) Хэрэв соёлын эд зүйлийг шилжүүлсэн, урьд өмнө нь шилжүүлсэн этгээдээр нөхөн олговорыг төлүүлж чадахгүй бол нэхэмжлэгч гуравдагч этгээдээр төлүүлэх боломжийг конвенцид тусгажээ. Энэ нь нөхөн төлбөр төлөх санхүүгийн чадваргүй нэхэмжлэгчид маш ашигтай бөгөөд аливаа бусад этгээд нь гадаадын ивээн тэтгэгч, олон улсын тусламжийн байгууллага, дотоодын цуглуулагч байж болно. (4) Худалдах-худалдан авах гэрээгээр хөрөнгийг худалдан авагч нь худалдагч этгээдээс эрхийн зөрчилгүй эд зүйл, түүнд хамаарах баримт бичиг, бусад холбогдох мэдээллийг шаардах эрхтэй байна. Олон улсын жишигт соёлын эд зүйлийг худалдах-худалдан авах гэрээний онцгой төрөл болох үнэ хаялцуулах замаар худалдах нь элбэг. СӨХТХ-иар иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг ашиглахыг зөвшөөрч, соёлын биет өв алдагдсан тохиолдолд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хариуцсан байгууллага холбогдох мэдээллийг хил, гааль, цагдаа, хяналтын байгууллагад нэн даруй хүргүүлэхээр зохицуулсан нь соёлын эд зүйлийг худалдан авагчид холбогдох бүртгэл, баримт, мэдээлэлтэй танилцах, эрх бүхий байгууллагаас лавлах боломжийг нээжээ. (Нэмж тодруулахад: Монгол улсад алдагдсан соёлын эд зүйлийн талаарх /бүртгүүлсэн тохиолдолд/ мэдээллийг ЦЕГ-ын “Эрэн сурвалжлах ASAP сан”-гаас, олон улсад эрэн сурвалжлагдаж буй соёлын эд зүйлийн талаарх мэдээллийг Интерполын хулгайлагдсан урлагийн бүтээлийн мэдээллийн сангаас хайж болно. Манай улсын эрх бүхий байгууллагууд соёлын эд зүйлийг худалдан авах ажлыг нээлттэй явуулж, түүх соёлын хосгүй үнэт зүйлийн жагсаалтад орсон дурсгалт зүйлийг гадаадын иргэн, харъяалалгүй хүнд худалдах, палеонтологи, археологийн олдворыг ямар ч тохиолдолд худалдахыг хориглож, зөрчвөл шийтгэл оногдуулахаар хуульчилсан байна. Соёлын өвийн хууль бус худалдааг зохион байгуулсан, зуулчилсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. (5) Соёлын

эд зүйлийг өвлөж эсхүл бэлгэнд үнэ төлбөргүй авсан эзэмшигч уг эд зүйлийг урьд нь хууль бусаар олж авсан гэдгийг мэдээгүй байж болно. Гэвч эзэмшигч, урьд шилжүүлсэн этгээдээс давуу эрх эдлэхгүй гэсэн нь урьд шилжүүлсэн этгээд шударга бус байсан бол дараагийн эзэмшигч шударга гэж нөхөн олговор авахгүй гэсэн үг. Иргэний хуулийн 494 дүгээр зүйлийн 494.1 заалт үүнтэй ижил агуулгатай.

III БҮЛЭГ. Хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийг буцаах

Б дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохиролцогч нэг улсын нутаг дэвсгэрээс хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлийг буцаах шийдвэр гаргах талаар тухайн улс Хэлэлцэн тохиролцогч нөгөө улсын шүүх болон эрх бүхий бусад байгууллагад хүсэлт гаргаж болно.

Иргэний хуулийн 7 дугаар зүйл. /Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч/ 7.1.Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна. 7.3.Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.

Иргэний хуулийн 545 дугаар зүйл. /Олон улсын иргэний эрх зүйн харилцаанд төр оролцогч болох нь/ 545.1.Олон улсын иргэний эрх зүйн харилцаанд төр нэг тал болон оролцож байгаа тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг хэрэглэнэ.

ИХШХШТХ-ийн 3 дугаар зүйл. /Шүүхэд мэдүүлэх эрх/ 3.1. Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй.

Иргэний хуулийн 106 дугаар зүйл. /Өмчлөгчийн шаардах эрх/ 106.1. Өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй.

(2) Хүсэлт гаргагч улсын соёлын өвийг хамгаалах болон соёлын эд зүйлсийн экспортын асуудлыг зохицуулсан хуулийн дагуу олгосон зөвшөөрлөөр тухайлбал үзэсгэлэн, шинжилгээ судалгаа болон сэргээн засварлах зорилготойгоор тухайн улсын нутаг дэвсгэрээс түр хугацаагаар экспортолсон соёлын үнэт зүйлс зөвшөөрлийн хугацаандаа эх орондоо эргэж ирээгүй бол хууль бусаар экспортолсон гэж үзнэ.

СӨХТХ-ийн 52 дугаар зүйл. /Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх/ 52.1.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг, сэргээн засварлах, сурталчлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Засгийн газрын зөвшөөрлөөр нэг жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлнэ. Энэ хэсгийн заалт нь түүний хувилсан эх хуулбарт хамаарахгүй. 52.3.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 52.1-д зааснаас бусад нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг дараах зорилгоор эргүүлэн авчрах нөхцөлтэйгөөр улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

52.3.1.палеонтологи, археологийн олдворыг судалж шинжлүүлэх;

52.3.2.сэргээн засварлах;

52.3.3.гадаад улсад үзэсгэлэнд гаргах;

52.4.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хоёр жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлнэ. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас уг хугацааг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн нэг удаа 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

ААҮАТЗТХ-ийн 15 дугаар зүйл. /Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл/ 15.1. Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ. 15.22. Соёлын чиглэлээр: 15.22.1.түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх;

Гаалийн тухай хуулийн 8 дугаар зүйл. /Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглох, хязгаарлах/ 8.4. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноос бусад тарифын бус хязгаарлалттай барааг хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн хилээр нэвтрүүлнэ.

Монгол Улсын хилээр тарифын бус бусад хязгаарлалттай нэвтрүүлэх бүлэг барааны жагсаалт. Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг сэргээн засварлах, сурталчлах зорилгоор оруулах, гаргах.

Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт. ХХI Хэсэг. Урлагийн бүтээл, цуглуулгын зүйлс ба эртний үнэт, ховор зүйлс /гаргах/ А.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл /Засгийн газрын 1995 оны 241, 1998 оны 126, 1999 оны 110 дугаар тогтоолоор баталсан түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлс хамаарна./ Гагцхүү судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор БСШУЯ-ны тогтоосон хугацаагаар. Б.Түүх, соёлын үнэт болон ердийн дурсгалт зүйл /Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалт, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг БСШУ-ны сайд батална. Энэ бүлэгт БСШУ-ны сайдын тушаалаар батлах түүх, соёлын үнэт дурсгалт зүйлс хамаарна./ Эргүүлж авчрах нөхцөлтэйгээр 2 жилээс дээшгүй хугацаагаар. Амьтан, ургамал эрдэс судлал, анатоми, археологи, палеонтологи, угсаатны зүй болон зоос судлалын чиглэлийн цуглуулга ба цуглуулгын зүйлс. Гаргах горимыг Засгийн газар, БСШУ-ны сайдаас баталсан тухайн зүйлийн зэрэглэлийн дагуу мөрдөнө.

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам. Нэг. Нийтлэг үндэслэл. 1.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хосгүй үнэт дурсгалт зүйлийг сэргээн засварлах, сурталчлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Засгийн газрын зөвшөөрлөөр Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө. Найм. Хариуцлага. 8.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам. Нэг. Нийтлэг үндэслэл. 1.2.Дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх лиценз авахаар хүсэлт гаргах, хүсэлтийг хянан шийдвэрлэх, лиценз олгох, лицензийн хэрэгжилтэд хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө. Ес. Хариуцлага. 9.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.

Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам. Нийтлэг үндэслэл. 1.1. "Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай" Улсын Их хурлын 1998 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Монгол Улсын олон улсын гэрээнд улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэхээр нэр төрлийг нь заасан бараанд экспорт, импортын лиценз /цаашид "лиценз" гэх/ олгоход энэхүү журмыг мөрдөнө.

Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горим хэрэгжүүлэх журам. Нэг. Нийтлэг үндэслэл. 1.5. Түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдворыг хилийн чанадад түр хугацаагаар гаргахад Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.4 дэх заалтын хугацааг баримтална.

Эрүүгийн хуулийн 25.6 дугаар зүйл. /Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх/

1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй, эсхүл түүх, соёлын дурсгалт зүйлийг завшсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

(3) Хүсэлт гаргагч улс нь тухайн эд зүйлийг өөрийнх нь нутаг дэвсгэрээс шилжүүлснээр дор дурдсан нэг болон түүнээс дээш ашиг сонирхлыг ноцтойгоор зөрчиж байгааг тогтоовол хүсэлтийг хүлээн авагч улсын шүүх болон бусад эрх бүхий байгууллага тухайн хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг буцаах шийдвэрийг гаргана. Үүнд:

(а) эд зүйлийн биет, эсхүл агуулгын хадгалалт,

(б) иж бүрэн эд зүйлийн бүрэн бүтэн байдал,

(с) шинжлэх ухааны, эсхүл түүхийн шинж чанартай мэдээллийн хадгалалт,

(д) уугуул иргэд, овог аймгийн уламжлал, эсхүл зан үйлд хэрэглэдэг эд зүйл, эсхүл тухайн эд зүйл нь хүсэлт гаргагч улсад соёлын чухал ач холбогдолтойг тогтоосон тохиолдолд,

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйл. 1.Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. 2. Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. 3. Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.

Шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйл. /Хуулийн нэр томъёоны тодорхойлолт/ 3.1.4. "шүүх" гэж Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг.

Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйл. /Шүүх хууль дээдлэх, гагцхүү хуульд захирагдах/ 6.3. Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.

Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйл. /Шүүхийн тогтолцоо/ 13.1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулсан шүүх хэрэгжүүлнэ.

Шүүхийн тухай хууль 22 дугаар зүйл. /Шүүхийн шийдвэр/ 22.1.Шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана. 22.4. Шүүх хэрэг, маргааныг хянан хэлэлцээд гаргасан шийдвэр нь дараах хэлбэртэй байна:

22.4.1.анхан шатны шүүх шийтгэх ба цагаатгах тогтоол, шүүхийн шийдвэр, шүүгч шийтгэвэр;

22.4.2.давж заалдах шатны шүүх магадлал;

22.4.3.хяналтын шатны шүүх тогтоол.

ИХШХШТХ-ийн 5 дугаар зүйл. /Шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлэх, шүүгч хараат бус байх/ 5.1. Шүүх эрх мэдлийг хуулийн дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ.

5.2. Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах бөгөөд шүүгч хараат бус байх баталгааг хуулиар тогтооно.

5.3. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төрийн болон төрийн бус байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

5.4. Энэ хуулийн 3.1-д заасны дагуу гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдлыг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс урьдчилан тогтоосон журмын дагуу шүүгчид хуваарилах бөгөөд уг журам нь урьдчилан мэдэх боломжгүй, тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байна. Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг үндэслэн тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг захирамж гарган томилно.

ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйл. /Шийдвэр/ 115.1. Анхан шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлээд гаргасан баримт бичгийг шийдвэр гэнэ. **115.2.** Анхан шатны шүүх хэргийн талаар дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

115.2.1. нэхэмжлэлийн шаардлагыг хангах;

115.2.2. нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгох; **115.2.3.** нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох.

ИХШХШТХ-ийн 116 дугаар зүйл. /Монгол Улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргах/

116.1. Шийдвэрийг Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана.

116.2. Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна.

116.3. Шийдвэрийг анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтын үндсэн дээр гаргана.

(4) Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу гаргасан аливаа хүсэлт нь, хүсэлт хүлээн авагч улсын шүүх болон эрх бүхий байгууллагад тус зүйлийн 1-ээс 3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлоход дөхөм болохуйц баримт, эсхүл эрх зүйн үндэслэлтэй мэдээллийг агуулсан, эсхүл хавсаргасан байна.

СӨХТХ-ийн 52 дугаар зүйл. /Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх/ 52.6. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу мэдээллийг үйлдэж, хадгалалтын байдлын тайлан, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулан соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалуулна.

ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйл. /Мэтгэлцэх зарчим/ 6.4. Зохигч шүүх хуралдаанд биеэр оролцож үг хэлэх, бичгээр тайлбар өгөх, нотлох баримт гаргах, түүнийг шинжлэн судлахад тэгш эрхтэй оролцоно. **6.5.** Зохигч гагцхүү бодит байдалд нийцсэн тайлбар өгөх, хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт гаргах үүрэгтэй.

ИХШХШТХ-ийн 37 дугаар зүйл. /Нотлох баримт/ 37.1. Хэргийн оролцогчоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ. **37.2.** Хэргийн нотлох баримт нь зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл ба цахим баримт, эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.

(5) Хүсэлт гаргагч улс буцаах хүсэлтийг соёлын эд зүйлийн байршил, эзэмшигчийг тогтоосон цагаас хойш гурван жилийн дотор гаргах бөгөөд аль ч тохиолдолд тухайн эд зүйл хууль бусаар экспортлогдсон өдрөөс, эсхүл энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон өдрөөс хойш тавин жилийн дотор гаргана.

Иргэний хуулийн 74 дүгээр зүйл. /Хөөн хэлэлцэх хугацаа хамаарах шаардах эрх/
74.1.Хуульд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүйгээр зааснаас бусад тохиолдолд өөр этгээдээс ямар нэг үйлдэл хийх буюу хийхгүй байхыг шаардах эрх хөөн хэлэлцэх хугацаатай байна.

Иргэний хуулийн 75 дугаар зүйл. /Хөөн хэлэлцэх өрөнхий болон тусгай хугацаа/
75.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хөөн хэлэлцэх өрөнхий хугацаа арван жил байна.

Иргэний хуулийн 90 дүгээр зүйл. /Шударга эзэмшигч/ 90.2. Шударга эзэмшигч өөрийн эзэмшлээс алдсан эд хөрөнгөө гурван жилийн дотор шинэ эзэмшигчээс буцаан шаардах эрхтэй. **90.3.**Хууран мэхлэх, хүч хэрэглэх замаар эд хөрөнгийг олж авснаас бусад тохиолдолд шинэ эзэмшигч тухайн эд хөрөнгийн хувьд өмнөх эзэмшигчээс илүү эрхтэй бол энэ хуулийн 90.2-т заасан журам үйлчлэхгүй.

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл. /Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа/ 1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй: **1.2.** энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;

Тайлбар дүгнэлт: Конвенцын энэ бүлэгт хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг буцаахтай холбоотой зохицуулалтыг тусгасан. (1) Соёлын эд зүйл нь хувийн эсвэл нийтийн өмч байхаас үл шалтгаалан зөвхөн улс хүсэлт гаргах бөгөөд хүсэлт гаргагч болон хүлээн авагч улс хоёулаа Конвенцын оролцогч улс байна. Монгол улсын хуулиар төр буюу улс иргэний эрх зүйн харилцааны оролцогч бөгөөд хууль ёсны ашиг хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд хүсэлт гаргах эрхтэй. Олон улсын иргэний эрх зүйн харилцаанд төр оролцохдоо хууль /гэрээ/-нд өөрөөр заасан бол түүнийг дагаж мөрдөнө. Өөрөөр заагаагүй бол Иргэний хуулийг хэрэглэнэ. (2) СӨХТХ болон холбогдох хууль, журамд зааснаар түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг сэргээн засварлах, сурталчлах зорилгоор эргүүлэн авчрах нөхцөлтэйгөөр 1 жил, бусад хөдлөх дурсгалт зүйлийг сэргээн засварлах, гадаад улсад үзэсгэлэнд гаргах, палеонтологи, археологийн олдворыг судалж шинжлүүлэх зорилгоор эргүүлэн авчрах нөхцөлтэйгөөр 2 жилээс дээшгүй хугацаагаар лицензийн дагуу улсын хилээр нэвтрүүлдэг. Харин Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалтад түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх ялгааг зөвхөн "гаргах" гэсэн нь хууль бусаар гадагш гарсан соёлын эд зүйлийг конвенцын дагуу оруулахад асуудал үүсгэж мэднэ. Тиймээс горимыг гаргах, оруулах болгож, хэсгийн гарчиг, зарим нэршил /эртний үнэт, ховор зүйлс, түүх, соёлын ердийн дурсгалт зүйл, БСШУЯ г.м/-ийг шинэчлэн найруулах шаардлагатай. Хуульд түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг "сурталчлах" гэснийг үзэсгэлэнд гаргах гэж ойлгож болох бол, хосгүй үнэт зүйлийг судлан шинжлүүлэх зорилгоор улсын хил нэвтрүүлэхгүй гэдэг нь тодорхой байна. Конвенцид үзэсгэлэн, шинжилгээ судалгаа, сэргээн засварлах 3 зорилгыг шууд нэрлэсэн нь товч, хийдэлгүй болжээ. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд улсын хилээр буцаан оруулж ирээгүйг конвенцид хууль бусаар экспортлосон гэж үзсэн, Монгол Улсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцсон нь харилцан уялдсан байна. (3) Энэ зүйлийн 1 болон 3, 4 дэх хэсэгт "бусад эрх бүхий байгууллага" гэж оруулсан нь зарим улсад энэ төрлийн асуудлыг шийдэх захиргааны шинжтэй байгууллага байдгийг харгалзан үзсэн хэрэг ажээ. Манай улсад тусгайлсан ийм байгууллага байхгүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэхээр заасан. Хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн аливаа этгээдээс эрхээ хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргаж, зөвхөн шүүх хэрэг, маргааныг хуульд заасан үндэслэл журмын дагуу хараат бусаар хянан шийдвэрлэнэ. Буцаах шийдвэр гаргах үндэслэл нь

соёлын эд зүйлийг хууль бусаар экспортолсноор тухайн эд зүйлд гэмтэл учруулсан, хөшөө, дурсгалын цогц байдлыг алдагдуулсан, шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийг үгүй хийсэн, түүнчлэн уугуул иргэд, овог аймгийн уламжлалт зан үйлд хэрэглэдэг, эсхүл соёлын чухал ач холбогдолтой зүйлд ноцтойгоор халдаж буйг нотолж тогтоосон байх явдал юм. Шүүхийн шийдвэрээр Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд, Соёлын сайд эрхлэх асуудлынхаа хүрээнд соёлын өвийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэж болно. (4) Шүүх болон эрх бүхий байгууллага цугларсан нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргана. Иймд буцаах хүсэлтэд соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн лавлагаа, түүх соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг тодорхойлсон гэрчилгээ, хууль бусаар малтсан, экспортлосон болохыг нотолсон мэдээлэл, баримт сэлт, тогтоосон хугацаанд буцаагдаагүй соёлын эд зүйлийн тухайд сэргээн засварлах, судлан шинжлэх, олон улсын үзэсгэлэнд оролцуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, байгуулсан гэрээ, экспортлох зөвшөөрөл, гаалийн бүрдүүлэлтийн материалыг хавсаргана гэсэн үг юм. (5) Конвенцын 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасантай адил хүсэлтийн хязгаарлах харьцангуй хугацааг 3 гэж тогтоосон нь Иргэний хуулийн шударга эзэмшигчийн шаардах эрхийн хугацаа /3 жил/-тай ижил, хууль бусаар экспортолсон, эсхүл түр хугацаагаар хилээр нэвтрүүлсэн соёлын эд зүйлийг буцаах тогтоосон /зөвшөөрлийн/ хугацаа дуусснаас хойш 50 жилийн дотор хүсэлт гаргаж болохоор заасан нь Иргэний хуулийн хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа /10 жил/-наас урт байна.

6 дугаар зүйл

(1) Соёлын эд зүйлийг хууль бусаар экспортлогдсоны дараа худалдан авсан эзэмшигч тухайн соёлын эд зүйлийг хууль бусаар экспортолсныг мэдээгүй бөгөөд мэдэх боломжгүй байсан тохиолдолд түүнийг буцаахдаа хүсэлт гаргагч улсаас шударга бөгөөд зохих нөхөн олговор авах эрхтэй.

Иргэний хуулийн 114 дүгээр зүйл. /Өмчлөх эрхийг шударгаар олж авах/ 114.1.Эд хөрөнгө шилжүүлж байгаа этгээд нь өмчлөгч биш болохыг өмчлөх эрх олж авч байгаа этгээд мэдээгүй бөгөөд мэдэх боломжгүй байсан бол түүнийг өмчлөх эрхийг шударгаар олж авсан гэж тооцно. Харин эрхээ шилжүүлж байгаа этгээд өмчлөгч биш болохыг тухайн үед мэдэж байсан буюу мэдэх ёстой буюу мэдэх боломжтой байсан бол өмчлөх эрхийг шударгаар олж авсан гэж үзэхгүй.

Иргэний хуулийн 493 дугаар зүйл. /Буцаан шаардах шаардлагад хамаарах зүйлс/ 493.5.Эд хөрөнгө олж авсан этгээд тухайн хөрөнгийг бүрмөсөн өөрийн болгосон гэж бодсоны улмаас түүнтэй холбоотой зардал гаргасан бол зардал, хохирлоо нөхөн төлүүлж уг зүйлийг буцааж өгөх үүрэгтэй. Харин хөрөнгийн шинж байдлаас түүнийг бүрмөсөн өөрийн болгож авсан гэж бодох үндэслэлгүй нь илтэд байвал энэ журам үл хамаарна. 493.6. Бусдын эд хөрөнгийг үндэслэлгүйгээр, шударга бусаар олж авсан этгээд ийнхүү эд хөрөнгийг олж авсан үеэс, шударгаар олж авсан этгээд нь үндэслэлгүйгээр олж авсан гэдгээ мэдсэн буюу мэдэх ёстой байсан үеэс эхлэн уг хөрөнгөөс олсон буюу өөрийн буруугаас олж чадаагүй зайлшгүй олох ёстой байсан орлого үр шимийг хууль ёсны өмчлөгч буюу эзэмшигчид буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэг хүлээнэ.

(2) Эзэмшигч нь тухайн соёлын эд зүйлсийг хууль бусаар экспортолсныг мэдэж байсан, эсхүл мэдэх боломжтой байсан эсэхийг тогтоохдоо эзэмшилд авсан үеийн бүхий л нөхцөл байдал, тухайлбал хүсэлт гаргагч улсын хуулийн дагуу шаардагдах экспортын гэрчилгээ байсан эсэхийг харгалзаж үзнэ.

СӨХТХ-ийн 10 дугаар зүйл. /Соёлын биет өвийн даатгал/ 10.1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үзэсгэлэнд оролцуулах, сэргээн засварлах, судалгаа шинжилгээ хийлгэх зорилгоор Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд заавал даатгуулна.

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам. Дөрөв. Лиценз олгох 4.1. Засгийн газраас хосгүй үнэт дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолоор баталсан "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам"-д заасны дагуу зөвшөөрөл хүсэгчид улсын хилээр нэвтрүүлэх лиценз (цаашид "лиценз" гэх) олгоно.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам. Дөрөв. Лиценз олгох

4.2. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан "Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам"-д заасны дагуу лицензийн эх хувь, хуулбар хувь /MNS 5022:2001 стандартын "D" хавсралт/-ийг тус бүр нэг хувь монгол хэлээр үйлдэнэ. Лицензийн өргөдөл, эх хувь, хуулбар хувьд Төрийн захиргааны төв байгууллагын соёлын асуудал хариуцсан нэгжийн дарга гарын үзэг зурж, яамны тэмдэг дарж баталгаажуулна.

Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам. Хоёр. Лиценз авах өргөдөл гаргах, хянан шийдвэрлэх журам. 2.6 Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол лицензийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан "MNS 5022:2001" стандартын "D" маягтаар олгоно.

Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам. Арван гурав. Бусад 13.3. Гаалийн хилээр нэвтрүүлэхийг хязгаарласан бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, барилгын материал, бүх төрлийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, түүхий эд, боловсруулаагүй эсхүл дахин боловсруулах бараа, химийн болон цацраг идэвхит бодис, ашигт малтмал, уул уурхайн бүтээгдэхүүн, түүх, соёлын дурсгалт зүйлс, палеонтологийн болон археологийн олдвор, шинжлэх ухаан, техникийн ололт, газар нутгийн дүрс, зураг зүйн бусад материал, судалгаа шинжилгээний материал, хүнсний бүтээгдэхүүн зэрэг бараанд "Барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас" /Маягт №2/-аар гаалийн бүрдүүлэлт хийхгүй.

Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журмын 2 дугаар хавсралт /MNS 5022:2001 стандартын D хавсралт/

Лиценз / License

Худалдагч/Seller	ORIGINAL	
	Лицензийн дугаар/ License ¹	Хүчинтэй хугацаа/Valid until
	Гэрээний дугаар/ Contract ¹	Он,сар, өдөр, /Date
Хүлээн авагч/Consignee	Худалдан авагч/ Buyer	
	Илгээх улс/Country of delivery	Гэрээт улс/Contracting country
	Гарал үүсэл/Country of origin	Хүлээн авах улс/Country of destination
Төлбөрийн нөхцөл/ Terms of payment		

Тээврийн төрөл/ Mode of transport		Валютын нэр /Currency		Ханш/ Rate	Хэлцлийн төрөл/Type of trade
Хилийн боомт/Port		Нэмэгдэл тайлбар/Supplementary details			
Барааны код Code	Барааны тодорхойлолт Commodity specification	Хэмжих нэгж Unit	Тоо хэмжээ Quantity	Нэгж үнэ Unit price	Үнэ Total

Дүн/ Total

.....Он, сар, өдөр/ Date

Тэмдэг/Stamp

Олгосон /Issued byГарын үсэр/ Signature

(3) Соёлын эд зүйлийг хүсэлт гаргагч улсад буцаах шаардлагатай эзэмшигч нь тухайн улстай тохиролцсоны үндсэн дээр нөхөн олговрын оронд дор дурдсан шийдвэрийг гаргаж болно. Үүнд:

(a) соёлын эд зүйлийг өмчлөх эрхийг хэвээр нь үлдээх,

(b) хүсэлт гаргагч улсад оршин суудаг; шаардлагатай батлагааг гаргаж өгсөн, өөрийн сонгосон этгээдэд төлбөртэй, эсхүл бэлгийн журмаар өмчлөх эрхийг шилжүүлэх.

(4) Энэхүү зүйлийн дагуу буцааж байгаа соёлын эд зүйлийг буцаахтай холбогдсон зардлыг хүсэлт гаргагч улс хариуцна. Хүсэлт гаргагч улс аливаа бусад этгээдээр зардлыг нөхөн төлүүлэх эрхтэй байна.

Иргэний хуулийн 94 дүгээр зүйл. /Шударга эзэмшигчийн эрх, үүрэг/ 94.3. Шударга эзэмшигч нь эд хөрөнгийг шударгаар эзэмшиж байхдаа түүнийг хадгалах, арчлах, засан сайжруулах зэрэгт зарцуулсан зардлыг эрх бүхий этгээдээс шаардах эрхтэй. 94.6. Шударга эзэмшигч, өөрийн шаардлага хангагдах хүртэл эд хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцааж өгөхөөс татгалзах эрхтэй.

Иргэний хуулийн 111 дүгээр зүйл. /Хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг шилжүүлэх/ 111.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн зохих журмын дагуу тавьсан шаардлагаар түүний эзэмшилд тухайн эд хөрөнгийг шилжүүлснээр хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно.111.2.Дараахь тохиолдолд эд хөрөнгийг шилжүүлсэн гэж үзнэ:

111.2.1.өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн эзэмшилд шилжүүлснээр;

111.2.2.өмчлөх эрх олж авч байгаа этгээдийн эзэмшилд тухайн эд хөрөнгө байгаа бол өмчлөх эрх шилжүүлэх тухай гэрээ байгуулснаар;

111.2.3.эд хөрөнгө нь гуравдагч этгээдийн эзэмшилд байвал өмчлөгч шаардах эрхээ өмчлөх эрхийг олж авч байгаа этгээдэд шилжүүлсэн гэрээ байгуулснаар.

Иргэний хуулийн 112 дугаар зүйл. /Эд хөрөнгийн үнийг төлснөөр өмчлөх эрх шилжих/

112.1.Талууд шилжүүлж байгаа эд хөрөнгийн үнийг бүрэн төлснөөр тухайн эд хөрөнгийг өмчлөх эрх шилжинэ гэж тохиролцсон бол ийнхүү үнийг бүрэн төлснөөр өмчлөх эрх шинэ өмчлөгчид шилжинэ.

112.2.Өмчлөх эрх олж авч байгаа этгээд эд хөрөнгийн үнийг хугацаанд нь төлөөгүй байхад өмчлөх эрхээ шилжүүлж байгаа этгээд гэрээнээсээ татгалзвал үүрэг ёсоор талууд өмнө нь шилжүүлсэн бүх зүйлээ харилцан буцааж өгөх үүрэгтэй. Энэ тохиолдолд тухайн эд хөрөнгийг өмчлөгч нь ердийн элэгдэл, хорогдлыг эс тооцон өөрт учирсан бодит хохирол, алдагдлаа нөхөн төлүүлэхээр үүргээ биелүүлээгүй талаас шаардах эрхтэй.

(5) Эзэмшигч нь түүнд тэрхүү соёлын эд зүйлийг өвлүүлсэн, эсхүл бэлгийн журмаар өгсөн хуучин эзэмшигчээс давуу эрх эдлэхгүй.

Иргэний хуулийн 494 дүгээр зүйл. /Хөрөнгийг буцаан шилжүүлэх гуравдагч этгээдийн үүрэг/ 494.1.Үндэслэлгүйгээр хөрөнгө олж авсан этгээд тухайн хөрөнгийг гуравдагч этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлсэн тохиолдолд гуравдагч этгээд уг хөрөнгийг эрх бүхий этгээдэд буцаан шилжүүлэх үүрэгтэй.

Тайлбар дүгнэлт: (1) Энд соёлын эд зүйлийг хууль бусаар экспортлогдсоны дараа худалдан авсан эзэмшигч нь хууль бус болохыг мэдээгүй, мэдэх боломжгүй байсан бол хүсэлт гаргагч улсаас зохих нөхөн олговор авахаар заажээ. Монгол Улсын Иргэний хуулийн 114 дүгээр зүйлд эзэмшигч нь эд хөрөнгийг шилжүүлэн авахдаа шилжүүлж байгаа этгээд өмчлөгч биш болохыг мэдээгүй, мэдэх боломжгүй байсан бол өмчлөх эрхийг шударгаар олж авсанд тооцно. Мөн хуулийн 493 дугаар зүйлд зааснаар эд хөрөнгө олж авсан этгээд нэг талаас тухайн хөрөнгийг бүрмөсөн өөрийн болгосон гэж бодсоны улмаас түүнтэй холбоотой зардал гаргасан бол зардал, хохирлоо нөхөн төлүүлэх, нөгөө талаас шударгаар олж авсан этгээд эд хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авсан гэдгээ мэдсэн буюу мэдэх ёстой байсан үеэс эхлэн олсон буюу зайлшгүй олох ёстой байсан орлого үр шимийг хууль ёсны өмчлөгч буюу эзэмшигчид буцааж өгөх үүрэгтэй байна. Нөхөн төлбөр авах эрхийн тухайд конвенцын 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил боловч эзэмшигч зохих идэвх зүтгэл гаргаснаа нотлохыг тусгаагүй. Гэхдээ энэ зүйлийн (2) дахь хэсэгт эзэмшилд авсан үеийн бүх нөхцөл байдал, тэр дундаа экспортын гэрчилгээг харгалзана гэжээ. Манай улсын түүх, соёлын хосгүй үнэт болон хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлсэн тухай баримтууд /сав, баглаа боодлын дардас, гаалийн тэмдэглэгээ, тайлан, гэрэл зураг, дүрс бичлэг, даатгалын баримт г.м/ нөхцөл байдлыг тодорхойлох ач холбогдолтой ба журмын дагуу "MNS 5022:2001" стандартын "D" маягтаар олгосон лиценз /зөвшөөрөл/ гол нотолгоо болно. Өөрөөр хэлбэл конвенцид дурдсан экспортын гэрчилгээ нь "D" маягтаар олгосон лиценз юм. (3) Эхний заалт нөхөн төлбөр төлж чадахгүй байгаа хүсэлт гаргагч улсад хохиролтой хоёр дахь заалт ашигтай. Гэхдээ эзэмшигч хүсэлт гаргагч улстай тохиролцсоны үндсэн дээр шийдвэр гаргана. Хүсэлт гаргагч улс эзэмшигчид эд зүйлийг өмчлөх эрхийг хадгалуулах магадлал багатай тул (b) хэсгийн заалт илүү анхаарал татна. Шударга эзэмшигч, хүсэлт гаргагч улсын аль алины эрх, ашиг сонирхлыг хүндэтгэсэн ийм нарийвчилсан заалт манайд байхгүй ч шударга эзэмшигчийн зардал шаардах, шаардлага хангагдах хүртэл эд хөрөнгийг буцаан өгөхөөс татгалзах эрхийг Иргэний хуулийн 94 дүгээр зүйлд, өмчлөх эрх шилжүүлэх нөхцөл, шаардах эрхийг Иргэний хуулийн 111, 112 дугаар зүйлд тус тус зааж өгчээ. Шаардлагатай баталгаа гэдэгт дахин хууль бусаар гадагш гаргахгүй, найдвартай хадгалж хамгаална гэсэн санаагаар ханджээ. Харин төлбөртэйгээр шилжүүлэн авах тохиолдол үнийг төлөх чадвартай байх болно. Этгээд гэдэгт зохиох баталгааг гаргаж өгч чадах хувь хүн, нийтийн эсвэл хувийн байгууллагуудыг (музей, урлагийн галлерей) хамруулан ойлгож болно. (4) Зардалд энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан эзэмшигчид төлөх нөхөн олговор бус захиргааны буюу хүсэлт гаргасан улс руу зөөх тээврийн болон даатгалын зардал багтана. Зардал төлөх аливаа бусад этгээд нь гадаад улс, олон улсын сан, дотоодын цуглуулагч г.м байх боломжтой. (5) Соёлын эд зүйлийг өвлөж эсхүл бэлгэнд үнэ төлбөргүй авсан эзэмшигч уг эд зүйлийг урьд

нь хэрхэн олж авсныг мэдэх боломжгүй байсан ч түүнд шилжүүлсэн этгээдтэй адил эрхтэй. Иргэний хуулийн 494 дүгээр зүйлд үндэслэлгүйгээр хөрөнгө шилжүүлэн авсан гуравдагч этгээд эрх бүхий этгээдэд буцаан шилжүүлэх үүрэгтэй гэжээ. Үүнээс конвенц ёсоор ч, дотоодын хуулийн дагуу ч шударга бус эзэмшигчээс эд зүйлийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан этгээд хууль бус болохыг мэдсэн эсэхээс үл хамааран шударга эзэмшигч болж чадахгүй.

7 дугаар зүйл

(1) Энэхүү бүлгийн заалтыг дор дурдсан нөхцөлд хэрэглэхгүй. Үүнд:

(а) буцаах хүсэлт гаргах үед соёлын эд зүйлийн экспорт нь хууль бус байхаа больсон, эсхүл

(б) эд зүйлийг бүтээсэн этгээдийг амьд байх хугацаанд, эсхүл түүнийг нас барснаас хойш 50 жилийн дотор экспортолсон тохиолдолд.

(2) Уугуул иргэд, овог аймгийн нэг буюу хэсэг гишүүд уламжлал, эсхүл зан үйлд зориулан бүтээсэн соёлын эд зүйлсийг өмнөх хэсгийн дэд хэсгийн заалтыг (б) үл харгалзан энэхүү бүлгийн заалтыг хэрэглэх бөгөөд эд зүйлийг тухайн нийгмийн бүлэгт буцаана.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. /Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацаа/ 14.1.Тодорхой бүтээлийн хувьд эдлэх зохиогчийн эрхийг хамгаалах хугацааг уг бүтээлийг туурвисан, эсхүл нийтэлсэн өдрөөс эхлэн тооцно. 14.2.Зохиогчийн амины эрхийг хугацаа хязгаарлахгүй хамгаална. 14.3.Зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчийн насан туршид болон нас барснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр байна. 14.4.Хавсарга урлагийн бүтээл ашиглах онцгой эрх нь уг бүтээлийг туурвиснаас хойш 25 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр байна. 14.5.Зохиогч бүтээлээ зохиомол, нууц нэрээр, эсхүл нэргүйгээр нийтэлсэн тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлийг анх нийтэлснээс хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр байна. 14.6.Энэ хуулийн 14.5-д заасан бүтээлийн зохиогч нь өөрийгөө ил болгосон, эсхүл бүтээлийн зохиогч нь тодорхой болсон тохиолдолд зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааг энэ хуулийн 14.3-т зааснаар тооцно. 14.7. Хамтын бүтээл ашиглах онцгой эрх нь зохиогчдын насан туршид болон сүүлчийн зохиогч нас барснаас хойш 50 дахь жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр байна.

Иргэний хуулийн 516 дугаар зүйл. /Оюуны үнэт зүйлийг өвлөх/

516.1.Оюуны үнэт зүйлийг өвлөх эрх гагцхүү эд хөрөнгийн эрхэд хамаарна. Оюуны үнэт зүйлийг өвлөх эрхийг хуульд зааснаар буюу гэрээслэлээр олж авч болно.

516.2.Оюуны үнэт зүйлийг өвлөх эрх 50 жилийн хугацаанд хадгалагдана.

Тайлбар дүгнэлт: (1) Конвенцын 3 дугаар бүлгийн заалтуудыг хэрэглэхгүй байх 2 нөхцлийг уг зүйлд зааж өгчээ. (а) Эхний тохиолдолд тухайн улсын экспортыг зохицуулсан хууль тогтоомж /Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Гаалийн тухай хууль, Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, заалт/ хүчингүй болсон, нэмэлт, өөрчлөлтөөр соёлын эд зүйлийг хууль бусаар экспортлосон асуудлыг хууль бус гэж үзэхгүй болсон байхыг хэлжээ. (б) Орчин үеийн урлагийг дэмжих, уран бүтээлчдийг олон улсад танигдаж, уран бүтээлээрээ амьдрах санхүүгийн эх үүсвэрийг хязгаарлахгүйн үүднээс 2 дахь заалтыг оруулсан байна. Эд зүйлийг бүтээсэн зохиогчийн амьд байх, нас барснаас хойш 50 жилийн хугацаанд үйлчлэхээр тогтоосон нь Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн Конвенцид нийцүүлсэн хэрэг бөгөөд үүгээрээ Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийн зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх болон Иргэний хуулийн оюуны үнэт зүйлийн өвлөх эрхийн хугацаатай тохирно. (2) 1 дүгээр заалтын (б) хэсгийн бүтээгч нь амьд сэрүүн байх, түүнийг нас барснаас хойш 50 жилийн хугацаа өнгөрсөн зэргийг үл

харгалзан тухайн соёлын эд зүйл нь овог аймаг, уугуул иргэд, үндэстэн, угсаатан /ястан/ ганцаар болон нийлж уламжлалт зан үйлд зориулж бүтээсэн бол энэ бүлгийн заалтуудыг хэрэглэж, тэдэнд буцаана. Мэдээж үүнийгээ нотлоно.

IV БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗААЛТ

8 дугаар зүйл

(1) II бүлгийн дагуу гаргах нэхэмжлэл болон III бүлгийн дагуу гаргах хүсэлтийг тухайн соёлын эд зүйл байрлаж байгаа Хэлэлцэн тохиролцогч улсын шүүх болон эрх бүхий бусад байгууллагад гаргахаас гадна Хэлэлцэн тохиролцогч улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар шүүн таслах бүрэн эрхтэй шүүх болон эрх бүхий бусад байгууллагад гаргаж болно.

(2) Талууд маргаанаа шүүх, арбитр, эрх бүхий бусад байгууллагаар дамжуулан шийдвэрлүүлэхээр тохиролцож болно.

(3) Эд зүйлийг эгүүлэн авах, эсхүл буцаах хүсэлтийг Хэлэлцэн тохиролцогч өөр нэг улсын шүүх болон эрх бүхий байгууллагад гаргасан байсан ч соёлын эд зүйл байрлаж байгаа Хэлэлцэн тохиролцогч улс нь өөрийн хуульд заасан түр зуурын хамгаалалтын арга хэмжээг авч болно.

ИХШХШТХ-ийн 13 дугаар зүйл. /Хэргийн харьяалал/

13.1. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдол /цаашид "нэхэмжлэл" гэх/-ыг шүүх харьяалан шийдвэрлэнэ.

13.2. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ.

13.3. Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал арбитраар шийдвэрлүүлэхээр заагаагүй буюу энэ талаар хэлэлцэн тохиролцоогүй, эсхүл Засгийн газар хоорондын хэлэлцээрээр маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр заагаагүй бол нэхэмжлэлийг шүүх шийдвэрлэнэ.

ИХШХШТХ-ийн 14 дүгээр зүйл. /Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа /оршин байгаа/ нутаг дэвсгэрийн харьяаллаар гаргах/

14.1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

14.2. Хариуцагч нь хуулийн этгээд байвал нэхэмжлэлийг түүний ажил хэргээ байнга явуулдаг, эсхүл удирдах байгууллага нь байгаа газрын шүүхэд гаргана.

14.3. Хариуцагчийн оршин суугаа газар мэдэгдэхгүй байвал нэхэмжлэлийг эд хөрөнгө нь байгаа газрын шүүхэд гаргаж болно.

Арбитрын тухай хуулийн 2 дугаар зүйл. /Хуулийн үйлчлэх хүрээ/ 2.1. Арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улс бол энэ хууль үйлчилнэ. **2.2.** Арбитрын ажиллагааны харьяалал нь Монгол Улсаас өөр улс, эсхүл тодорхойлогдоогүй байсан ч арбитрын ажиллагаанд энэ хуулийн 10, 11, 27, 28, 29, 39, 48, 49 дүгээр зүйл үйлчилнэ.

Арбитрын тухай хуулийн 3 дугаар зүйл. /Арбитрын ажиллагаа/ 3.1. Арбитрын ажиллагаа гэдэгт байнгын, эсхүл түр арбитраас явуулж байгаа арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг ойлгоно. **3.2.** Олон улсын арбитрын ажиллагаанд дараахь арбитрын ажиллагаа хамаарна:

3.2.1. арбитрын хэлэлцээр байгуулах үед уг хэлэлцээрийн талууд өөр өөр улсад үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

3.2.2. арбитрын хэлэлцээрт заасан, эсхүл түүнд тодорхойлсон арбитрын ажиллагааны харьяалал нь талуудын үйл ажиллагаа явуулж байгаа газраас өөр тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

3.2.3. арилжааны харилцаанаас үүсэх үүргийн ихэнхийг гүйцэтгэх газар, эсхүл маргааны зүйлтэй илүү холбоотой газар нь талуудын үйл ажиллагаа явуулж байгаа газраас өөр тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа;

3.2.4. арбитрын хэлэлцээрээс үүсэх харилцаа нэгээс олон улсад хамаарна гэдгийг талууд тодорхой тохиролцсон тохиолдолд хийгдэх арбитрын ажиллагаа.

Арбитрын тухай хуулийн 48 дугаар зүйл. /Үндсэн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх/ 48.1. Аль улсад гаргаснаас үл хамааран арбитрын үндсэн шийдвэрийг заавал биелүүлэх хүчинтэй гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд харьяалах шүүхэд бичгээр өргөдөл гаргаснаар энэ хуулийн 48, 49 дүгээр зүйл болон Гадаадын арбитрын байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай 1958 оны Нью Йоркийн конвенцид заасан журмын дагуу арбитрын үндсэн шийдвэрийг гүйцэтгэнэ.

ИХШХШТХ-ийн 69 дүгээр зүйл. /Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах/

69.1.Шүүгч нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах дараахь арга хэмжээг хэрэг үүсгэхдээ буюу үүсгэсний дараа захирамж гарган авах эрхтэй:

69.1.1.хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр битүүмжлэх;

69.1.2.хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр хориглох;

69.1.3.хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээнд зогсоох;

69.1.4.нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд урьдчилан оруулах;

69.1.5.тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах.

69.2.Шүүгч энэ хуулийн 69.1-д заасан хэд хэдэн арга хэмжээг нэгэн зэрэг авч болно.

ЭХХШТХ-ийн 21.2 дугаар зүйл. /Эд хөрөнгө битүүмжлэх/

1.Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ.

2.Шүүх, прокурорын шийдвэрээр хураан авсан эд мөрийн баримт овор хэмжээ ихтэй, эсхүл бусад шалтгаанаар хадгалах боломжгүй бол мөрдөгч байгаа газарт нь битүүмжилнэ.

3.Эд хөрөнгийг битүүмжлэхдээ эд хөрөнгөө бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, өөрт нь, эсхүл бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэнэ.

Тайлбар дүгнэлт: (1) Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэхээр заасныг 5 зүйлд дурдсан. Иргэний журмаар гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдол болон эрүүгийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэлийг зөвхөн шүүх харьяалан шийдвэрлэнэ хэдий ч Иргэний хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ гэжээ. (2) Төвийг сахисан, түргэн шуурхай, илүү мэргэшсэн арбитрыг сонгон маргаанаа шийдвэрлүүлэх боломжийг олгосон конвенцын энэ заалт ИХХШТХ болон Арбитрын тухай хуультай зохицож байна. Хууль, олон улсын гэрээнд заасан бөгөөд талууд ийнхүү тохиролцож болно. (3) Соёлын эд зүйл худалдагдах, эсвэл өөр улс руу экспортлогдохоос урьдчилан сэргийлж эд зүйл байгаа хэлэлцэн тохирогч улсын хуулийн дагуу боломжтой түр зуурын хамгаалалтын арга хэмжээ авах нь

шүүхийн ажиллагаа болж буй үед нэхэмжлэгчийн эрх болон эд зүйлийг эвдрэл гэмтлээс хамгаалах ач холбогдолтой. Монгол улсын хуульд заасны дагуу иргэний болон эрүүгийн процессын үе шатанд тухайн соёлын эд зүйлийг битүүжлэх байдлаар түр зуурын хамгаалалтын арга хэмжээ авч болох юм.

9 дүгээр зүйл

(1) Хэлэлцэн тохиролцогч улс хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг эгүүлэн олгох, буцаах талаар энэхүү конвенцид зааснаас илүү таатай дүрмийг мөрдөхийг тус конвенц хязгаарлахгүй.

(2) Энэхүү зүйлийг Хэлэлцэн тохиролцогч бусад улсын шүүх болон эрх бүхий байгууллагын тус конвенцид зааснаас ангид шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, эсхүл хэрэгжүүлэх үүргийг бий болгохоор тайлбарлахгүй.

Иргэний хуулийн 540 дүгээр зүйл. /Гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх/

540.1. Шаардлагатай бол шүүх иргэний хэрэг, маргаан шийдвэрлэх буюу иргэний эрх зүйн бусад харилцааг зохицуулахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харшлаагүй гадаад улсын хууль, эрх зүйн болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэж болно.

540.2. Гадаад улсын хуульд Монгол Улсын хуулийг баримтлахаар заасан бол Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

540.3. Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээнд ямарваа нэгэн эрх зүйн харилцааг тодорхойлоогүй, эсхүл түүнийг өөр нэрийн дор ялгаатай агуулгаар тодорхойлсон бөгөөд Монгол Улсын эрх зүйн хэмжээг тайлбарлах аргаар тодорхойлж болохооргүй бол түүний эрх зүйн ангиллыг тогтооход тухайн эрх зүйн харилцаа зохицуулсан гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг харгалзаж болно.

ИХШХШТХ-ийн 10 дугаар зүйл. /Хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх/

10.1. Шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хуулийг хэрэглэнэ.

10.4. Тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол шүүх төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ. Хэрэв тийм хууль байхгүй бол шүүх Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн шийдвэрлэнэ.

10.5. Монгол Улсын Үндсэн хуульд харшлахгүй бол шүүх олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхдээ олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэж болно.

Тайлбар дүгнэлт: (1) Тус заалт боломж олгосон, өөрөөр хэлбэл хулгайлагдсан соёлын эд зүйлийг эгүүлэн олгох, буцаахад энэхүү Конвенцоос илүү үр дүнтэй зохицуулалтыг хэрэглэхийг үгүйсгээгүй. Иргэний болон ИХХШТХ-д дотоод, гадаадын хууль тогтоомж, олон улсын хэм хэмжээг шууд, эсхүл төсөөтэй хэрэглэх, харгалзах үндэслэлийг хуульчилсан байна. Магадгүй 2 улсын хооронд байгуулсан 2 талт гэрээ, тухайн улсын соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжийг хэрэглэх нь харилцан ашигтай байж болно. Хэдийгээр конвенцын зохицуулалтаас давуу хууль тогтоомжийг хэрэглэж болох ч энэ нь өөр хэлэлцэн тохирогч улсын шүүх эсхүл эрх бүхий байгууллагын гаргасан уг конвенцын зарчим, заалтуудтай үл нийцэх шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон үг биш болохыг (2) хэсэгт анхааруулжээ.

10 дугаар зүйл

(1) II бүлгийн заалтыг зөвхөн нэхэмжлэл хүргүүлсэн улсад энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа хулгайлагдсан соёлын эд зүйлийн хувьд дор дурдсан нөхцөлд хэрэглэнэ. Үүнд:

(а) энэхүү конвенц Хэлэлцэн тохиролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсны дараа тухайн улсын нутаг дэвсгэрээс соёлын эд зүйл хулгайлагдсан, эсхүл

(б) энэхүү конвенц Хэлэлцэн тохиролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсны дараа тухайн улсын нутаг дэвсгэрт соёлын эд зүйл олдсон тохиолдолд

(2) Хүсэлт гаргагч болоод түүнийг хүлээн авагч улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш III бүлгийн заалтыг зөвхөн хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийн хувьд мөрдлөг болгоно.

(3) Энэхүү конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө үйлдэгдсэн аливаа хууль бус шинжтэй эсхүл энэхүү зүйлийн 1 ба 2 дахь хэсэгт заасан аливаа төрлийн хууль бус арилжааг аль ч байдлаар хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд энэ конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө хулгайлагдсан болон хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг энэхүү конвенцын хүрээнээс гаднах бусад эрх зүйн зохицуулалтаар эгүүлэн олгох, буцаах нэхэмжлэл гаргах аливаа улс, хувь хүний эрхийг хязгаарлаагүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйл.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

**Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын Хорин дөрөвдүгээр зүйл.
/Хүчин төгөлдөр болох/**

1. Гэрээ нь түүнд заасан буюу хэлэлцээнд оролцогч улсуудын тохиролцсон журам, он, сар, өдөр хүчин төгөлдөр болно.

2. Дээрх заалт буюу тохиролцоо байхгүй үед хэлэлцээнд оролцогч бүх улс гэрээг заавал биелүүлэхээ зөвшөөрч байгаагаа илэрхийлмэгц уг гэрээ хүчин төгөлдөр болно.

3. Хэрэв улс гэрээ хүчин төгөлдөр болсны дараахь тодорхой он, сар, өдрөөс заавал биелүүлэхээ зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн бол тухайн улсын хувьд уг гэрээ дээрх он, сар, өдрөөс эхлэн, хэрэв гэрээнд өөрөөр заагаагүй бол, хүчин төгөлдөр болно.

4. Гэрээний эх бичвэрийг адил хүчинтэйг тогтоох, гэрээг заавал биелүүлэхээ зөвшөөрч байгаагаа улс илэрхийлэх, гэрээ хүчин төгөлдөр болох журам, он, сар, өдөр, тайлбар, гэрээний эх хадгалагчийн үүрэг болон гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө зайлшгүй гарч буй бусад асуудлыг зохицуулж байгаа гэрээний заалтуудыг гэрээний эх бичвэрийг хүлээн зөвшөөрсөн үеэс эхлэн хэрэглэнэ.

Тайлбар дүгнэлт: (1) Хулгайлагдсан соёлын эд зүйлийг эгүүлэн олгох (2) Хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг буцаах шалгуур буюу конвенцыг хэрэглэх нөхцлийг тодорхойлжээ. Товчоор хэлбэл соёлын эд зүйлээ хулгайд, эсхүл хууль бус экспортын улмаас алдсан буюу нэхэмжлэл, хүсэлт гаргагч улс, тэрхүү соёлын эд зүйл оршин байгаа буюу нэхэмжлэл, хүсэлтийг хүлээн авагч улсад конвенц хүчин төгөлдөр болсон байх ёстой. Гэхдээ конвенцын тайлбарт конвенц хүчин төгөлдөр болсон хэлэлцэн тохиролцогч улсаас соёлын эд зүйлийг хулгайлсан тохиолдолд нэхэмжлэл гаргах үед эд зүйл хэлэлцэн тохиролцогч бус улсын нутаг дэвсгэр дээр байсан ч, хулгайлагдсан соёлын эд зүйл хэлэлцэн тохиролцогч улсын нутаг дэвсгэр дээр байгаа бол /нэхэмжлэл хүлээн авагч нь хэлэлцэн тохиролцогч улс байвал/ соёлын эд зүйл хэлэлцэн тохиролцогч эсхүл хэлэлцэн тохиролцогч бус улсаас хулгайлагдсан эсэх нь хамаагүй конвенц хэрэгжих боломжтой гэжээ. Харин үүний гол бэрхшээл нь эгүүлэн олгох шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэхэд буйг онцолсон байна. Монгол Улсын Үндсэн хуульд олон улсын гэрээг соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэсэн бөгөөд манай улс 1988 оны 4 сарын 11-нд нэгдэн орсон Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын дагуу олон улсын гэрээ нь түүнд заасан журам, он, сар, өдөр хүчин төгөлдөр болно. Конвенцын 12 дугаар

зүйлд хүчин төгөлдөр болох хугацаа, нөхцлийг тодорхой заасан тул ойлгомжтой. (3) Конвенц ирээдүйд чиглэсэн бөгөөд буцаан хэрэглэхгүй. Гэхдээ энэ нь урьд гарсан хулгай, хууль бус наймааг цайруулах гэсэн хэрэг биш болохоор конвенц хүчин төгөлдөр болохоос өмнөх асуудалд 1970 оны Конвенц, ЗГ хоорондын гэрээ, бусад хууль тогтоомжийг ашиглаж болно. Конвенцын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт үүнийг зааж өгсөн.

V БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

11 дүгээр зүйл

(1) Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийг олон улсын хэмжээнд буцаах тухай ЮНИДРУА-ийн конвенцын төслийг батлах Дипломат бага хурлын хаалтын хуралдааны үеэр тус конвенцид гарын үсэг зурахад нээлттэй байх бөгөөд үүнээс хойш 1996 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл Ром хотноо бүх улс гарын үсэг зурахад нээлттэй хэвээр байна.

(2) Энэхүү конвенцид гарын үсэг зурсан улс түүнийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, эсхүл батална.

(3) Энэхүү конвенцид гарын үсэг зурахад нээлттэй болсон өдрөөс эхлэн гарын үсэг зураагүй бусад улс нэгдэн ороход нээлттэй байна.

(4) Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай албан ёсны баримт бичгийг эх хадгалагчид хадгалуулна.

Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйл. /Хуулийн нэр томьёоны тодорхойлолт/ 3.1.3."Батламж жуух бичиг" гэж олон улсын гэрээг Монгол Улсын Их Хурал соёрхон баталж хууль гаргасныг нотолж байгаа баримт бичгийг; 3.1.5."Гэрээнд нэгдэн орох" гэж хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээг Монгол Улс тухайн гэрээгээр хүлээн зөвшөөрсөн арга, энэ хуульд заасны дагуу заавал биелүүлэхээ олон улсын хэмжээнд зөвшөөрсөн үйлдлийг; 3.1.8."гарын үсэг зурах" гэж энэ хуульд заасны дагуу эрх олгогдсон албан тушаалтан Монгол Улс, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж олон улсын гэрээнд гарын үсэг зурах үйлдлийг хэлэх бөгөөд гарын үсгийн эрх зүйн чадамж, үр дагавар нь Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц, энэ хууль, тухайн олон улсын гэрээгээр тодорхойлогдохыг;

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйл. /Заавал соёрхон батлах олон улсын гэрээ/ 8.1.Улсын Их Хурал дараахь олон улсын гэрээг заавал соёрхон батална:

8.1.1.Монгол Улсын бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, нутаг дэвсгэр, улсын хил болон хүний салшгүй эрхтэй холбогдсон олон улсын гэрээ;

8.1.2.гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ;

8.1.3.Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ;

8.1.4.эрх зүйн тусгалцаа үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээ;

8.1.5.чөлөөт худалдаа, давхар татвар, хөрөнгө оруулалттай холбогдсон олон улсын гэрээ;

8.1.6.батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны олон улсын ерөнхий гэрээ.

Олон улсын гэрээний тухай хуулийн 16 дугаар зүйл. /Олон улсын гэрээг соёрхон батлах/ 16.2.Засгийн газар гарын үсэг зурсан заавал соёрхон батлах олон талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал, тухайн олон улсын гэрээний эх бичвэрийн хуулбар, боломжтой бол баталгаат хуулбар, тухайн олон улсын гэрээний энэ

хуулийн 7.6-д заасны дагуу хянан баталгаажуулсан монгол хэл дээрх орчуулга болон холбогдох бусад баримт бичгийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

16.3. Улсын Их Хурал энэ зүйлийн 16.1, 16.2-т заасны дагуу өргөн мэдүүлсэн олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хууль, дэмжээгүй бол хуулийн төслийг Засгийн газарт буцаах тухай тогтоол гаргана.

Олон улсын гэрээний тухай хуулийн 19 дүгээр зүйл. /Батламж жуух бичгийг харилцан солилцох, хадгалуулах/ 19.1. Олон улсын гэрээг соёрхон баталсан тухай Монгол Улсын хуулийг үндэслэн гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан тухай Батламж жуух бичгийг олон улсын эрх зүйн тогтсон томъёоллын дагуу хоёр хувь үйлдэнэ.

19.2. Батламж жуух бичигт Монгол Улсын Ерөнхийлөгч, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж, төрийн тамга дарна.

19.3. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батламж жуух бичгийг хоёр талт олон улсын гэрээний нөгөө талтай харилцан солилцох, олон талт олон улсын гэрээний эх хадгалагч улс, эсхүл олон улсын байгууллагад хүргүүлж, хадгалуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

Тайлбар дүгнэлт: Конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах болон нэгдэн орох журмыг энэ зүйлд заажээ. (1) 1996 оны 6 дугаар сарын 30 хүртэл бүх улс гарын үсэг зурах нээлттэй байсан. Манай улсын хувьд энэхүү хугацаанд гарын үсэг зураагүй тул энэ зүйлийн (3) дахь хэсгийн дагуу нэгдэн орох боломжтой юм. Гэрээнд нэгдэн орно гэдэг нь тухайн олон талт олон улсын гэрээг хүлээн зөвшөөрч биелүүлэхээ олон улсын хэмжээнд мэдэгдэж буй үйлдэл бөгөөд Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар тус конвенц нь Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа тул соёрхон баталж хууль гаргана. (4) Олон улсын гэрээг Монгол Улсын Их Хурал соёрхон баталж хууль гаргасныг нотолж байгаа баримт бичиг /батламж жуух бичиг/-ийг гэрээний эх хадгалагч /Итали улсын Засгийн газар/-т хадгалуулах ажлыг тус конвенц болон дотоодын хуульд заасны дагуу ГХЯ хариуцан гүйцэтгэнэ.

12 дугаар зүйл

(1) Энэхүү конвенц нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай тав дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш зургаа дахь сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр болно.

(2) Энэхүү конвенцийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай тав дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөний дараа соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон улс бүрийн хувьд тухайн улсын соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш зургаа дахь сарын эхний өдрөөс энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйл. /Улсын Их Хурлын шийдвэр/

5.1. Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд Улсын Их Хурлын бусад шийдвэр тогтоолын хэлбэртэй байна.

5.2. Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг цахимаар болон "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд албан ёсоор бүрэн эхээр нь нийтэлнэ.

5.3. Улсын Их Хурлын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

5.4.Тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Монгол Улсын Ерөнхийлөгч /цаашид "Ерөнхийлөгч" гэх/-ийн хориг тавьсан хугацаатай давхацвал хоригийг хэрхэх тухай асуудлыг Улсын Их Хурал хянан хэлэлцэж дуусах хүртэл уг хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно.

5.5.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ Улсын Их Хурлын цахим хуудсанд болон "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ.

Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын Хорин дөрөвдүгээр зүйл. /Хүчин төгөлдөр болох/

1. Гэрээ нь түүнд заасан буюу хэлэлцээнд оролцогч улсуудын тохиролцсон журам, он, сар, өдөр хүчин төгөлдөр болно.

2. Дээрх заалт буюу тохиролцоо байхгүй үед хэлэлцээнд оролцогч бүх улс гэрээг заавал биелүүлэхээ зөвшөөрч байгаагаа илэрхийлмэгц уг гэрээ хүчин төгөлдөр болно.

3. Хэрэв улс гэрээ хүчин төгөлдөр болсны дараахь тодорхой он, сар, өдрөөс заавал биелүүлэхээ зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн бол тухайн улсын хувьд уг гэрээ дээрх он, сар, өдрөөс эхлэн, хэрэв гэрээнд өөрөөр заагаагүй бол, хүчин төгөлдөр болно.

4. Гэрээний эх бичвэрийг адил хүчинтэйг тогтоох, гэрээг заавал биелүүлэхээ зөвшөөрч байгаагаа улс илэрхийлэх, гэрээ хүчин төгөлдөр болох журам, он, сар, өдөр, тайлбар, гэрээний эх хадгалагчийн үүрэг болон гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө зайлшгүй гарч буй бусад асуудлыг зохицуулж байгаа гэрээний заалтуудыг гэрээний эх бичвэрийг хүлээн зөвшөөрсөн үеэс эхлэн хэрэглэнэ.

Тайлбар дүгнэлт: Олон улсын гэрээ хүчин төгөлдөр болоход шаардагдах баримт бичгийн тоо олон янз. Хамгийн багадаа 3 байдаг бол энэ конвенцид 5 гэжээ. (1) дэх хэсэгт хэлэлцэн тохиролцогч улсуудын хувьд; (2) дахь хэсэгт тухайн улсын хувьд конвенц хүчин төгөлдөр болох хугацааг заасан байна. Конвенцыг соёрхон баталсан тухай хууль гармагц, эсхүл "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болохгүй бөгөөд Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцид гэрээ нь түүнд заасан буюу оролцогч улсуудын тохиролцсон журам, он, сар, өдөр хүчин төгөлдөр болно гэснийг үндэслэн энэхүү 12 дугаар зүйлийн дагуу 5 дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс 6 сарын дараа конвенц хүчин төгөлдөр болно.

13 дугаар зүйл

(1) Олон улсын аливаа баримт бичгээр үүрэг хүлээсэн Хэлэлцэн тохиролцогч улс аливаа эсрэг мэдэгдэл хийснээс бусад тохиолдолд энэхүү конвенцоор зохицуулж буй асуудалтай холбогдох заалтыг агуулсан олон улсын баримт бичигт энэхүү конвенц нөлөөлөхгүй.

(2) Энэхүү конвенцын хэрэгжилтийг сайжруулах үүднээс Хэлэлцэн тохиролцогч аливаа улс Хэлэлцэн тохиролцогч нэг болон хэд хэдэн улстай өөр хоорондын харилцаагаа зохицуулсан хэлэлцээр байгуулж болно. Хэлэлцээр байгуулсан улс хувийг нь эх хадгалагчид хүргүүлнэ.

(3) Эдийн засгийн интеграц, эсхүл бүс нутгийн байгууллагын гишүүн болох Хэлэлцэн тохиролцогч улсын өөр хоорондын харилцаа нь эдгээр байгууллагын дотоод дүрмээр зохицуулагдаж байгаа бөгөөд энэхүү дотоод дүрэм нь тус конвенцын хэрэглэх хүрээтэй давхцаж байвал энэхүү конвенцын заалтыг хэрэглэхгүй талаар мэдэгдэл хийж болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйл. /Хуулийн нэр томьёоны тодорхойлолт/ 3.1.7."тайлбар" гэж олон улсын гэрээ байгуулахдаа тухайн гэрээний тодорхой заалтыг Монгол Улсын хувьд хэрэгжүүлэхэд хуулийн үйлчлэлийг нь хасах, эсхүл өөрчлөх зорилгоор энэ хуульд заасны дагуу гаргасан мэдэгдлийг;

Тайлбар дүгнэлт: Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулиар тухайн гэрээний тодорхой заалтыг хэрэгжүүлэхэд хуулийн үйлчлэлийг хасах, өөрчлөх талаар хуульд заасны дагуу гаргасан мэдэгдлийг тайлбар гэнэ. (1) Хэрэв мэдэгдэл буюу тайлбар хийгээгүй бол тухайн улс урьд нэгдэн орсон энэ конвенцын зохицуулж буй асуудлыг хамарсан заалт бүхий заавал биелүүлэх үүрэгтэй олон улсын бусад баримт бичиг дагаж мөрдөнө. Манай улсын хувьд соёлын эд зүйлийн хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр нэгдэн орсон "Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" 1970 оны ЮНЕСКО-гийн Конвенцоор хүлээсэн үүргийнхээ дагуу эсрэг мэдэгдэл хийхгүй. (2) Аливаа хэлэлцэн тохирогч улс нэг болон түүнээс олон хэлэлцэн тохирогч улстай энэ конвенцын хэрэгжилтийг сайжруулах үүднээс гэрээ байгуулж болно. Уг гэрээндээ хөрөнгө шилжүүлэх, зардал төлөх зэрэгтэй холбоотой илүү давуу заалтыг 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хэрэглэх талаар тусгаж болох юм. Одоогоор тус конвенцын оролцогч улсуудаас 2 дахь заалтаар мэдэгдэл хийсэн улс байхгүй байна. (3) Конвенцид нэгдэн орсон Финланд, Грек, /Голланд/ Итали, Испани, Норвеги, Швед зэрэг улсууд ийм мэдэгдэл хийжээ. Монгол улсад бүс нутаг, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд гадаадын гишүүн улсуудтай харилцан дагаж мөрдөх ийм агуулга, давхцал бүхий дүрэмгүй учир мэдэгдэл, тайлбар хийх шаардлагагүй.

14 дүгээр зүйл

(1) Хоёр болон түүнээс дээш нутаг дэвсгэрийн нэгжтэй Хэлэлцэн тохиролцогч улс эдгээр нутаг дэвсгэртээ тус конвенцын зохицуулж буй асуудлаар эрх зүйн өөр өөр тогтолцоотой эсэхээс үл шалтгаалан гарын үсэг зурах, эсхүл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан баримт бичгээ хадгалуулах үедээ энэхүү конвенц нь тухайн улсын бүх нутаг дэвсгэрт, эсхүл нэг болон хэд хэдэн нэгжид нь хүчин төгөлдөр байх тухай мэдэгдэл хийж болох бөгөөд энэхүү мэдэгдлийг хүссэн цагтаа өөр мэдэгдлээр сольж болно.

(2) Энэхүү мэдэгдлээ эх хадгалагчид хүргүүлэх бөгөөд энэхүү конвенц хүчин төгөлдөр үйлчлэх нутаг дэвсгэрийг тодорхой заана.

(3) Энэхүү зүйлийн дагуу хийсэн мэдэгдлээр энэхүү конвенц Хэлэлцэн тохиролцогч улсын бүх нутаг дэвсгэрт бус, нэг буюу хэд хэдэн нутаг дэвсгэрийн нэгжид хүчин төгөлдөр байгаа бол дор дурдсанаар ойлгоно. Үүнд:

(a) 1 дүгээр зүйлд заасан Хэлэлцэн тохиролцогч улсын нутаг дэвсгэр гэж тус улсын нутаг дэвсгэрийн нэгжийн газар нутгийг;

(b) Хэлэлцэн тохиролцогч улсын, эсхүл хүсэлт гаргагч улсын шүүх буюу эрх бүхий байгууллага гэж тус улсын нутаг дэвсгэрийн нэгжийн шүүх буюу эрх бүхий байгууллагыг;

(c) 8 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад зааснаар соёлын эд зүйл байрлаж байгаа Хэлэлцэн тохиролцогч улс гэж тухайн эд зүйл байгаа улсын нутаг дэвсгэрийн нэгжийг;

(d) 8 дугаар зүйлийн 3 дугаар заалтад зааснаар соёлын эд зүйл байрлаж байгаа Хэлэлцэн тохиролцогч улсын хууль гэж тухайн эд зүйл байгаа улсын нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийг;

(e) 9 дүгээр зүйлд заасан Хэлэлцэн тохиролцогч улс гэж тус улсын нутаг дэвсгэрийн нэгжийг ойлгоно.

(4) Хэрэв Хэлэлцэн тохиролцогч улс энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу мэдэгдэл хийгээгүй бол энэ конвенц тухайн улсын нутаг дэвсгэрийн бүх нэгжид хэрэгжинэ.

Монгол Улсын Үндсэн Хуулийн хоёрдугаар зүйл.

1. Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.

2. Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 1 дүгээр зүйл. /Хуулийн зорилт/

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах, иргэд орон нутгийн үйл хэрэгт шууд болон сонгож байгуулсан төлөөллийн байгууллагаараа уламжлан оролцох эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршино.

Тайлбар дүгнэлт: Энэ зүйлийг холбооны төрийн байгууламжтай улс орнуудад зориулан боловсруулжээ. Манай улс төрийн байгууламжийн хувьд хувьд нэгдмэл бөгөөд нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагддаг. Үүнийг үл харгалзан мэдэгдэл хийж болох ч ингэх шаардлагагүй юм. Тиймээс (2), (3) дахь заалтуудыг орхъё. (4) Нэгэнт 1 дэх заалтын дагуу мэдэгдэл хийхгүй тул конвенц хүчин төгөлдөр болмогц Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилнэ.

15 дугаар зүйл

(1) Энэхүү конвенцид гарын үсэг зурах үед хийсэн мэдэгдлийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах үедээ баталгаажуулна.

(2) Мэдэгдэл, түүний баталгааг бичгээр үйлдэж эх хадгалагчид албан ёсоор мэдэгдэнэ.

(3) Мэдэгдэл хийсэн улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс мэдэгдэл нь хүчин төгөлдөр болно. Харин энэ хугацаанаас хойш албан ёсоор хадгалагчид ирүүлсэн мэдэгдэл нь мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаа дахь сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр болно.

(4) Аливаа улс энэхүү конвенцын дагуу хийсэн мэдэгдлээ эх хадгалагчид албан ёсоор бичгээр мэдэгдэн татан авч болно. Ийнхүү эх хадгалагчид мэдэгдсэн өдрөөс хойш зургаа дахь сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 21 дүгээр зүйл. /Тайлбар хийх, эсэргүүцэх, эгүүлэн авах/ 21.1.Улсын Их Хурал, Засгийн газар олон талт олон улсын гэрээг соёрхон батлах, батлахдаа тайлбар хийсэн бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан Монгол Улсын хууль, баталсан Засгийн газрын тогтоолыг орчуулж тухайн олон улсын гэрээний зохицуулалтын дагуу холбогдох улс, эсхүл олон улсын байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авна.

21.2.Энэ зүйлийн 21.1-д заасны дагуу үйлдсэн тайлбарыг тухайн олон улсын гэрээг соёрхон баталсан тухай Батламж жуух бичиг, эсхүл баталсан тухай баримт бичигтэй хамт хүргүүлнэ.

21.3.Олон талт олон улсын гэрээнд тайлбар хийх саналыг боловсруулахдаа тухайн олон улсын гэрээгээр тайлбар хийх боломжтой эсэх, тайлбар хийх боломжит хүрээ, тухайн олон улсын гэрээний бусад талын, эсхүл олон улсын байгууллагын зөвшөөрөл шаардлагатай эсэх зэрэг зохицуулалтыг харгалзана.

21.5.Олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах саналыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр холбогдох журмын дагуу Улсын Их Хурал, эсхүл Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

21.6.Соёрхон баталсан олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон талт олон улсын гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах шийдвэрийг Засгийн газар гаргана.

Тайлбар дүгнэлт: Энэ зүйл бүхэлдээ мэдэгдэл хийх журмыг тодорхойлсон. (1) Мэдэгдлээ баталгаажуулах, (2) баталгаажуулалтаа мэдэгдэх, (3) мэдэгдэл хүчин төгөлдөр болох, (4) мэдэгдлийг эгүүлэн авах талаар тусгажээ. Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуульд олон улсын олон талт гэрээг соёрхон батлахдаа тайлбар мэдэгдэл хийх, эх хадгалагчид хүргүүлэх, эгүүлэн авах шийдвэр гаргах журмыг заажээ. Конвенцид тайлбар буюу мэдэгдэл, түүнийг цуцлах шийдвэр хүчин төгөлдөр болох хугацаа /6 дахь

сарын эхний өдөр/-г зааж өгчээ. Энэ зүйл, заалт нь Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенцын 2 дугаар бүлэгт заасан тайлбар /мэдэгдэл/ хийхтэй холбоотой зохицуулалт болон манай улсын хуультай нийцжээ.

16 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохиролцогч улс бүр энэхүү конвенцид гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох үедээ 8 дугаар зүйлд заасан соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэл, эсхүл буцаах хүсэлтээ дор дурдсан нэг буюу хэд хэдэн журмын дагуу гаргаж болохоо мэдэгдэнэ. Үүнд:

(а) шууд тухайн улсын шүүх болон эрх бүхий байгууллагад;

(b) энэ төрлийн нэхэмжлэл, эсхүл хүсэлтийг хүлээн авч шүүх болон эрх бүхий байгууллагад дамжуулах үүрэг бүхий тухайн улсын томилсон нэг буюу хэд хэдэн газарт;

(с) дипломат болон консулын шугамаар.

(2) Хэлэлцэн тохиролцогч улс бүр II болон III бүлгийн заалтын дагуу соёлын эд зүйлсийг эгүүлэн олгох, буцаах шийдвэр гаргах шүүх болон эрх бүхий байгууллагыг томилж болно.

(3) Энэхүү зүйлийн 1 ба 2 дахь хэсгийн дагуу хийсэн мэдэгдлийг хэдийд ч өөр мэдэгдлээр шинэчилж болно.

(4) Энэхүү зүйлийн 1-ээс 3 дахь хэсгийн заалт Хэлэлцэн тохиролцогч улсуудын хооронд байгуулсан байж болзошгүй иргэний болон худалдааны асуудлаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хоёр талт болон олон талт хэлэлцээрт нөлөөлөхгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйл. 1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. **2.** Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. **3.** Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.

Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйл. /Шүүхийн тогтолцоо/ 13.1. Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулсан шүүх хэрэгжүүлнэ.

ИХШХШТХ-ийн 5 дугаар зүйл. /Шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлэх, шүүгч хараат бус байх/ 5.1. Шүүх эрх мэдлийг хуулийн дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ.

Дипломат харилцааны тухай Венийн Конвенцын 3 дугаар зүйл. 1. Дипломат төлөөлөгчийн газрын чиг үүрэг *inter alia* дор дурдсанд оршино: **(b)** томилогч улсын болон түүний иргэдийн ашиг сонирхлыг хүлээн авагч улсад олон улсын эрх зүйн хүрээнд хамгаалах; **(e)** томилогч улс болон хүлээн авагч улсын хооронд найрсаг харилцааг хөгжүүлэх, мөн тэдгээрийн хооронд эдийн засаг, соёл, шинжлэх ухааны салбарт харилцаа хөгжүүлэх.

Консулын харилцааны тухай Венийн Конвенцын 5 дугаар зүйл. /Консулын чиг үүрэг/

Консулын чиг үүрэгт дор дурдсан ажил орно:

(a) томилогч улс, түүний харьяат хувь хүн болон хуулийн этгээдийн ашиг сонирхлыг хүлээн авагч улсад олон улсын эрх зүйн хүрээнд хамгаалах;

(b) томилогч улс, хүлээн авагч улсын хооронд худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны харилцааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх, мөн тэдгээрийн хооронд найрсаг харилцааг энэхүү конвенцын заалтын дагуу бусад арга замаар хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх;

Дипломат албаны тухай хуулийн 5 дугаар зүйл. /Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг/ 5.1.3. Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, байр суурь, нэр хүндийг олон улсын хэмжээнд дипломат аргаар бататган хамгаалах;

Дипломат албаны тухай хуулийн 7 дугаар зүйл. /Дипломат төлөөлөгчийн газрын чиг үүрэг/ 7.1. Дипломат төлөөлөгчийн газар дараахь чиг үүргийг гүйцэтгэнэ: 7.1.5. хилийн чанадад Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах;

Тайлбар дүгнэлт: Конвенцын мэдэгдлүүдээс ганцхан эгүүлэн олгох нэхэмжлэл, буцаах хүсэлт гаргах журамтай холбоотой 16 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасан мэдэгдлийг улс орнууд зайлшгүй гаргах бөгөөд бусад хулгайлсан эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэлийн хязгаарлах хугацаа, конвенцыг заалтыг хэрэглэхгүй байх, үйлчлэх нутаг дэвсгэр, шүүх болон эрх бүхий байгууллагыг томилохтой холбоотой 3(5), 13(3), 14(1), 16(2)-д заасан мэдэгдлүүдийг сайн дураараа хийнэ. (а) Монгол Улсад шүүх эрх мэдлийг зөвхөн Үндсэн хууль болон шүүхийн тухай хуулийн дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ. Түүнчлэн хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий байгууллага байхгүйн дээр (б) ийм нэхэмжлэл, хүсэлтийг хүлээн авч шүүхэд дамжуулах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагыг одоогоор манай улс томилоогүй. Зарим улсад соёлын эд зүйлийн хууль бус худалдаатай тэмцэх захиргааны шинжтэй байгууллага байдаг. (с) ГХЯ, дипломат төлөөлөгчийн газар, консулын байгууллага нь хилийн чандад үндэсний болон иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд дипломат аргаар хамгаалах чиг үүрэгтэй. Мөн ЮНЕСКО-гийн 1970 оны конвенц ёсоор соёлын үнэт зүйлсийг эрэн сурвалжлах болон эгүүлэн өгөх тухай хүсэлтийг дипломат шугамаар дамжуулна. (2) Конвенцын 2, 3 дугаар бүлэгт заасан соёлын эд зүйлийг эргүүлэн олгох, буцаах шийдвэр гаргах чадамж бүхий шүүх эсвэл эрх бүхий байгууллагыг хэлэлцэн тохирогч улс томилон, түүнийгээ мэдэгдэж, (3) 1, 2 дахь хэсгийн дагуу гаргасан мэдэгдлийг хэдийд ч өөрчилж болно. Ийнхүү өөрчилсөн тухай мэдэгдэл хүчин төгөлдөр болох хугацааг 15 дугаар зүйлд зааснаар тооцно. (4) Хэлэлцэн тохирогч улсууд иргэний болон худалдааны чиглэлээр байгуулсан, нэгдэн орсон бүх төрлийн гэрээг дагаж мөрдөхөд энэ зүйлийн мэдэгдлүүд нөлөөлөхгүй. Эдгээр байдлыг харгалзан соёлын эд зүйлийг эргүүлэн олгох нэхэмжлэл, буцаах хүсэлтийг шүүхэд шууд, эсвэл дипломат болон консулын шугамаар гаргах талаар мэдэгдэл хийж болохоор байна. Яг ийм сонголтыг Иран, Итали, Перу, Хойд Македон, Того, Тунис зэрэг улсууд хийжээ. Магадгүй нөгөө улсад нэхэмжлэл, хүсэлт гаргана гэдгээрээ (б) хувилбарыг нэмж болох ч манай улсад ийм томилгоот нэгж байхгүй тул шаардлагагүй юм.

17 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч улс бүр соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш зургаан сарын дотор өөрийн улсын соёлын эд зүйлсийн экспортын асуудлыг зохицуулсан хууль тогтоомжийн тухай мэдээллийг энэхүү конвенцын албан ёсны хэлний аль нэгээр үйлдэн эх хадгалагчид бичгээр хүргүүлнэ. Мэдээллийг тухай бүрт шинэчилнэ.

Тайлбар дүгнэлт: Олон улсын гэрээг соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг хадгалуулахаар хүргүүлж, конвенц хүчин төгөлдөр болох хүртэлх /6 сар/ хугацаанд багтаж соёлын эд зүйлсийн экспортыг зохицуулсан хууль тогтоомжийн талаарх мэдээллийг Конвенцын албан ёсны /англи, франц/ аль нэг хэл дээр орчуулж хадгалагчид хүргүүлэх ёстой. Энэ мэдээлэл ЮНИДРУА-гийн олон нийтийн бүртгэл мэдээллийн санд хадгалагдах бөгөөд соёлын эд зүйлийг худалдан авах үед гарал үүслийг магадлан хянах үүднээс тухайн улсын соёлын өвийн экспорттой холбоотой хууль тогтоомжийг мэдэх, нягтлах хэрэгцээ гарна. Тухайлбал, ЮНЕСКО-гийн Үндэсний соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжийн жагсаалтад гишүүн орнуудын соёлын өвтэй холбоотой хууль тогтоомжууд эх хэлээрээ болон орчуулгатай байдаг. Түүнд Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль монгол, англи хэл дээр байршсан. Бидний зүгээс Конвенцид

нэгдэн орвол Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Монгол Улсын хилээр тарифын бус бусад хязгаарлалттай нэвтрүүлэх бүлэг барааны жагсаалт, Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалтын холбогдох хэсгийг, Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам, Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам, Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам зэргийг бүхэлд нь орчуулж дурдсан хугацаанд хүргүүлж, мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр шинэчлэх шаардлагатай.

18 дугаар зүйл

Энэхүү конвенцоор тусгайлан эрх олгосноос бусад тохиолдолд тайлбар хийхийг хориглоно.

Тайлбар дүгнэлт: Конвенцид ямар нэгэн тайлбар байхгүй. Конвенцын 15 дугаар зүйлд заасан журмын дагуу мэдэгдэл гаргаж болох боловч тайлбар хийх замаар нэг ч заалтыг өөрчилж, эсвэл хасахгүй. Өөрөөр хэлбэл конвенцид заасны дагуу мэдэгдэл хийх нь түүнийг ямар нэгэн байдлаар тайлбарлаж байгаа хэрэг биш юм.

19 дүгээр зүйл

(1) Аливаа Оролцогч улс тухайн улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хэдийд ч албан ёсны баримт бичгийг эх хадгалагчид хүргүүлэн цуцалж болно.

(2) Цуцлах тухай баримт бичгийг эх хадгалагчид хүргүүлсэн өдрөөс хойш зургаа дахь сарын эхний өдрөөс эхлэн цуцлалт нь хүчин төгөлдөр болно. Цуцлах тухай баримт бичигт цуцлалт хүчин төгөлдөр болоход илүү урт хугацаа шаардагдахаар заасан бол эх хадгалагчид хүргүүлснээс хойш тэрхүү хугацаа дуусгавар болмогц цуцлалт хүчин төгөлдөр болно.

(3) Цуцлалт хүчин төгөлдөр болохоос өмнө соёлын эд зүйлийг эгүүлэн авах нэхэмжлэл, эсхүл буцаах хүсэлт гаргасан бол дээрх цуцлалтыг үл харгалзан энэхүү конвенцийг хэрэглэнэ.

Олон улсын гэрээний тухай хуулийн 24 дүгээр зүйл. /Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, биелэлтэд хяналт тавих/ 24.6. Олон улсын гэрээний үүргээ биелүүлэхгүй байгаа бол олон улсын гэрээний үүргээ биелүүлэх шаардлагыг олон улсын гэрээний нөгөө тал, эсхүл бусад талд тавих, шаардлагатай бол тухайн олон улсын гэрээний үйлчлэлийг дуусгавар болгох, цуцлах, гарах, эсхүл үйлчлэлийг түр зогсоох саналыг Улсын Их Хурал, эсхүл Засгийн газраар хэлэлцүүлнэ.

Олон улсын гэрээний тухай хуулийн 29 дүгээр зүйл. /Олон улсын гэрээг цуцлах, олон улсын гэрээнээс гарах, гэрээний үйлчлэлийг түр зогсоох/

29.1. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ олон улсын гэрээний нөгөө тал, эсхүл бусад тал үл биелүүлсэн, эсхүл удаа дараа зөрчсөн тохиолдолд болон тухайн олон улсын гэрээний зохицуулалтын дагуу олон улсын гэрээг цуцлах, олон талт олон улсын гэрээнээс гарах, түүний үйлчлэлийг түр зогсоох саналыг тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж болно.

29.2. Соёрхон баталсан олон улсын гэрээг цуцлах, олон талт олон улсын гэрээнээс гарах, олон улсын гэрээний үйлчлэлийг түр зогсоох эсэх асуудлыг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал, бусад олон улсын гэрээний хувьд Засгийн газар энэ зүйлийн 29.1-д заасан саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

29.3.Олон улсын гэрээний үйлчлэлийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, олон улсын гэрээг цуцлах, олон талт олон улсын гэрээнээс гарах, олон улсын гэрээний үйлчлэлийг түр зогсоох шийдвэр гаргасан бол Улсын Их Хурал хууль, Засгийн газар тогтоол батална.

Тайлбар дүгнэлт: Хүчин төгөлдөр болсон конвенцийг цуцлах талаар энэ зүйлд тусгасан байна. Гэхдээ үндэслэлийг тодорхой заагаагүй, процедурыг тусгажээ. (1) Гэрээний хадгалагч талд цуцлах тухай баримт бичиг хадгалуулах замаар хэзээ ч цуцлаж болно. (2) Цуцлах баримт бичигт хадгалуулснаас хойш 6 сарын эхний өдрөөс цуцлалтыг дагаж мөрдөнө. Хэрэв цуцлах тухай баримт бичигт 6 сараас илүү урт хугацааг заасан бол тэрхүү хугацаа дуусахад цуцлалтыг дагаж мөрдөнө. (3) Харин цуцлалтыг дагаж мөрдөх огнооноос өмнө соёлын эд зүйлийг эргүүлэн олгох нэхэмжлэл, буцаах хүсэлтэд гаргасан байвал конвенц үйлчилнэ. Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуульд олон улсын гэрээний бусад тал олон улсын гэрээний үүргээ биелүүлэхгүй бол шаардлага тавих, эсхүл гэрээг цуцлах саналыг УИХ, ЗГ хэлэлцэж, тогтоол батлахаар заасан байна. Олон улсын гэрээнээс гарах буюу денонсаци хийх тохиолдол түгээмэл биш ч энэхүү гэрээ, дотоодын хуулийн дагуу гэрээг цуцлах асуудал нээлттэй байна.

20 дугаар зүйл

Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн (ЮНИДРУА) ерөнхийлөгч нь энэхүү конвенцын хэрэгжилтийг шалгах зорилгоор тогтмол, эсхүл Хэлэлцэн тохиролцогч таван улсын хүсэлтээр тусгай хороо зарлан хуралдуулж болно.

Тайлбар дүгнэлт: Конвенцын хэрэгжилтийг хянах механизмтай болох үүднээс тусгай хороог байгуулжээ. Гэвч хорооны чиг үүргийг нарийвчлан тодорхойлоогүй. Ажлын хэсгийг хэн шүүх болон эрх бүхий байгууллагуудад хүргэгдсэн хэргийг хянах, зөвлөмж гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэж тооцсон байна. Тусгай хороог ЮНИДРУА, эсвэл 5 хэлэлцэн тохирогч улсын хүсэлтээр хэдийд ч зарлан хуралдуулж болох ажээ.

21 дүгээр зүйл

(1) Энэхүү конвенцийг Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар хадгална.

(2) Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар:

(а) энэхүү конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсон бүх улс болон Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн (ЮНИДРУА) ерөнхийлөгчид дор дурдсан зүйлийг мэдээлнэ. Үүнд:

- i. соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон болон шинээр гарын үсэг зурсан тухай баримт бичиг бүрийг, түүний огнооны хамт;**
- ii. энэхүү конвенцын дагуу хийсэн мэдэгдэл бүрийн тухай;**
- iii. хүчингүй болгосон аливаа мэдэгдлийн тухай;**
- iv. энэхүү конвенц хүчин төгөлдөр болох хугацаа;**
- v. 13 дугаар зүйлд заасан хэлэлцээрийн тухай;**
- vi. энэхүү конвенцийг цуцлах тухай баримт бичиг, түүний хүргүүлсэн огноо болон хүчингүй болох огнооны тухай**

(б) энэхүү конвенцид гарын үсэг зурсан болон нэгдэн орсон бүх улс болон Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэнгийн (ЮНИДРУА) ерөнхийлөгчид энэхүү конвенцын баталгаат хуулбарыг хүргүүлнэ.

(с) Эх хадгалагчид оногддог бусад холбогдох ажлыг гүйцэтгэнэ.

Дээрхийг нотолж дор дурдсан эрх бүхий төлөөлөгчид бүрэн эрхийнхээ дагуу энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Нэг мянга өсөн зуун ерэн таван оны зургаадугаар сарын хорин дөрөвний энэ өдөр Ром хотноо англи болон франц хэлээр нэг эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр нь адил хүчинтэй байна.

Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенцын 76 зүйл. /Гэрээ хадгалагч/

1. Гэрээ хадгалагчийг хэлэлцээнд буюу уг гэрээнд оролцогч улсууд, эсхүл ямар нэгэн өөр журмаар томилж болно. Гэрээ хадгалагчаар нэг буюу хэд хэдэн улс, олон улсын байгууллага буюу тийм байгууллагын гүйцэтгэх гол албан тушаалтан байж болно.

Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенцын 77 дугаар зүйл. /Гэрээ хадгалагчийн үүрэг/ 1.Хэрэв гэрээнд өөрөөр заагаагүй буюу хэлэлцэн тохирогч улсууд өөрөөр тохиролцоогүй бол гэрээ хадгалагч дор дурдсан үүрэгтэй байна:

а/гэрээний жинхэнэ эх бичвэр, гэрээ хадгалагчид гардуулсан бүрэн эрхийн үнэмлэхийг хадгалах;

б/гэрээний жинхэнэ эх бичвэрээс баталгаатай хуулбар бэлтгэх, гэрээгээр зааж болох аль нэг хэлээр гэрээний эх бичвэрийг бэлтгэх, түүнчлэн тэдгээрийг оролцогч улсууд болон оролцох бүхий улсуудад илгээх;

в/гэрээнд гарын үсэг авах, гэрээтэй холбогдсон баримт бичиг, мэдэгдэл, мэдээг хүлээн авах, хадгалах;

г/гэрээнд хамаарах гарын үсэг, баримт бичиг, мэдэгдэл буюу мэдээ нь зохих хэлбэр, журмаар үйлдэгдсэн эсэх тухай асуудлыг судлах, шаардлагатай тохиолдолд энэ асуудлыг холбогдох улсад мэдэгдэх;

д/гэрээнд хамаарах баримт бичиг, мэдэгдэл болон мэдээний талаар оролцогчдод болон оролцох эрх бүхий улсуудад мэдэгдэх;

е/гэрээ хүчин төгөлдөр болоход шаардагдах тооны гарын үсэг, батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хүлээн авсан буюу хадгалуулсан тухай гэрээнд оролцох эрх бүхий улсуудад мэдэгдэх;

ё/Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт гэрээг бүртгүүлэх; ж/энэхүү Конвенцын бусад заалтад дурдсан үүргийг гүйцэтгэх.

Тайлбар дүгнэлт: (1) Конвенцийг Ром хотноо баталсан бөгөөд Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар энэ Конвенцийг хадгалагч байна. (2) Хадгалагчийн гүйцэтгэх үүргийг зааж өгсөн. Олон улсын гэрээний тухай Венийн Конвенцид заасны дагуу гэрээний хадгалагч нь нэг буюу хэд хэдэн улс, эсхүл олон улсын байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтан байж болно. Энэхүү Конвенцын хадгалагч улс нь гэрээнд гарын үсэг авах, гэрээтэй холбогдсон баримт бичиг, мэдэгдэл, мэдээг хүлээн авах, хадгалах, мэдээлэх, бусад ажлуудыг гүйцэтгэнэ.

“Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.5.Асуудалд дүн шинжилгээ хийж, зохицуулалтын хувилбаруудыг сонгож тандан судлах явцад тухайн асуудлыг зөвхөн хууль гаргах замаар шийдвэрлэнэ гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд хууль тогтоомжийн төслийн бүтэц, агуулга, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах шаардлагатай хууль тогтоомжийг ерөнхий байдлаар томъёолж бичнэ,⁶⁸ Олон улсын гэрээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.Улсын Их Хурал олон талт олон улсын гэрээг соёрхон батлахдаа тайлбар хийхээр шийдвэрлэсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуульд энэ тухай тусгай заалт оруулна⁶⁹ гэснийг тус тус үндэслэн хуулийн төслийг дараах байдлаар томъёолов.

⁶⁸ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

⁶⁹ Олон улсын гэрээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017, №02